



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД
НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД
ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭ



2026 он



Судалгааг хянасан:

Н.Жамъянхүү

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор, (Ph.D)

Судалгааг гүйцэтгэсэн:

Г.Билгүүн

Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын эрдэм шинжилгээний ажилтан



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	5
УДИРТГАЛ	6
НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ.....	8
ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ	9
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	9
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	10
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	10
2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	10
2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	11
ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	12
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	13
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	24
3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	35
3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	40
3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	54
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	58
НОМ ЗҮЙ.....	64



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ИРИМ	ИРИМ Нийгэм, бодлогын тусгаар судалгааны хүрээлэн
МЭСНБЭХТТХ	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХТТХ	Хууль тогтоомжийн тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХМХТХ	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль
ШТС	Шатахуун түгээх станц
ЭХНӨОТХ	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
BtMG	Betäubungsmittelgesetz Германы Мансууруулах бодисын тухай хууль (1971)
EMCDDA	European Monitoring Centre for Drugs and Drug Addiction Европын мансууруулах бодис, донтолтын хяналтын төв
ICCPR	International Covenant on Civil and Political Rights Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)
ICD-11	International Classification of Diseases, 11th Revision Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын өвчний олон улсын ангилал, 11 дэх хувилбар
M-LET	Mongolia Law Enforcement Training Монгол Улсын Хууль сахиулах сургалтын санаачилга (UNODC-тай хамтарсан)
MNS	Mongolian National Standard
NPS	New Psychoactive Substances Шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодис
OECD	Organisation for Economic Co-operation and Development Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
OGP	Open Government Partnership Нээлттэй Засгийн газрын түншлэл
ROSEAP	UNODC Regional Office for Southeast Asia and the Pacific UNODC-ийн Зүүн өмнөд Ази, Номхон далайн бүсийн газар
UNODC	United Nations Office on Drugs and Crime НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар
WHO	World Health Organization Дэлхийн эрүүл мэндийн байгууллага



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт	9
Хүснэгт 2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд.....	10
Хүснэгт 3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт	11
Хүснэгт 4. Тохирох шалгах хэрэгсэл	12
Хүснэгт 5. Тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг үнэлэх хэсэг	12
Хүснэгт 6. Зорилтын агуулга, үр дүн	18
Хүснэгт 7. Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ ..	35
Хүснэгт 8. Хуулийн төслийн Бүлгийн дарааллын логик шинжилгээ	37
Хүснэгт 9. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх.	38
Хүснэгт 10. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал	40
Хүснэгт 11. ЭХНӨОтХ-ийн төсөл дэх холбогдох гэмт хэргийн зохицуулалтад тусгасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал	42
Хүснэгт 12. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал	54



УДИРТГАЛ


Монгол Улсын эрх зүйн орчинд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн системийг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага үүсээд удаж байна. Энэхүү шаардлага нь нэг талаас дотоодын нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, мансууруулах бодис хэрэглэгчдийн тоо, бүтэц, хэрэглээний хэв маягийн өөрчлөлт, гэмт хэргийн тоон үзүүлэлтийн өсөлтөөс үүдэж буй бол нөгөө талаас олон улсын хамтын нийгэмлэгийн бодлого, хандлагын өөрчлөлт, шинэ төрлийн синтетик мансууруулах бодисын тархалт, олон улсын гэрээ конвенцийн шинэчилсэн шаардлагуудтай холбоотой юм. Эдгээр дотоод болон гадаад хүчин зүйлсийн нийлбэр үр дүнд Монгол Улсын одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2002 оны Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын тухай хууль нь цаг үеийн шаардлагад нийцэхгүй болсон гэж үзэх үндэслэл бүрдсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тооцож, шинжилгээ хийх нь хууль тогтоомжийн чанар, хэрэгжих боломж, нийгэмд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг урьдчилан тодорхойлох, хуулийн хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болдог. Энэхүү үр нөлөөний үнэлгээ нь "Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай" хуулийн шинэ төслийг хууль тогтоомжийн системд нэвтрүүлэхийн өмнө түүний үр нөлөө, ач холбогдол, хэрэгжих боломж, нийгэм-эдийн засгийн үр дагаврыг шинжлэн судалсан бичиг баримт юм.

Монгол Улс дэлхийн хэмжээнд мансууруулах бодисын хувьд "дамжин өнгөрөх улс" гэсэн статустай байсан бол сүүлийн арваад жилийн хугацаанд "хэрэглэгч улс" болж хувирсан нь судалгааны мэдээллээр нотлогдож байна. Тодруулбал, Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээллээр 2002 онд мансууруулах бодистой холбоотой бүртгэгдсэн гэмт хэрэг ердөө 2 байсан бол 2023 онд 197 хүртэл өссөн нь 200 гаруй дахин өсөлттэй болсныг харуулж байна. Энэхүү өсөлт нь зөвхөн тоон өөрчлөлт төдийгүй, чанарын хувьд ч томоохон өөрчлөлтүүдийг агуулж байгаа бөгөөд үүнд шинэ төрлийн синтетик мансууруулах бодисын тархалт, залуучуудын дунд хэрэглээ нэмэгдэх, интернет орчинг ашиглан мансууруулах бодисын хууль бус худалдаа хийх зэрэг орно.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль нь 17 зүйлээс бүрддэг харьцангуй товч хуулийн бүтэцтэй бөгөөд олон улсын стандартын дагуу шинэ төрлийн мансууруулах бодисыг ангилах, хяналт тавих, эмчлэн сэргээх үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, байгууллага хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх зэрэг олон асуудлыг зохицуулахад хүрэлцэхгүй байна. Энэ шалтгаанаар шинэ хуулийн төслийг боловсруулах шаардлага үүссэн бөгөөд тус төсөл нь 9 бүлэг, 75 зүйлээс бүрдэх, илүү дэлгэрэнгүй, системчилсэн бүтэцтэй хууль болж байгаа юм.

Энэхүү судалгааны зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал /цаашид "Аргачлал" гэх/-ын дагуу тус Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд оршино. Ийнхүү үнэлэхдээ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн зохицуулалт, агуулга нь үзэл баримтлал, зорилгод нийцэж буй эсэх, зохион байгуулалтыг өөрчилж буй зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх, шинээр тусгагдсан зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдсөн эсэх, хуулийн төсөл нь хууль зүйн техникийн хувьд алдаатай эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгсөн болно.



Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар үнэллээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Журмын төслөөс үр нөлөө тооцох хэсгээ сонгох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.



НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 6 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал
5. Зардал¹
6. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Тухайлбал,

1. Хуулийн төслийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээ болон хуулийн төслийн бүтэц нь өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилго, хууль батлагдах хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх;
2. Хуулийн төсөлд өөрчлөгдсөн зохицуулалт болох мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эргэлтэд хяналт тавих тогтолцоо зэрэг зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх;
3. Хуулийн төсөлд тусгагдсан нэр томъёонууд нь ойлгомжтой эсэх, мөн хууль зүйн техникийн алдаа бий эсэх;
4. Хуулийн төсөлд шинээр тусгагдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх, магадлан шинжилгээ хийх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээ, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сан, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, гэмт хэрэг, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах гэмт хэрэг, зөрчил үйлдэж, ял, шийтгэл хүлээсэн этгээдэд хяналт тавих зэрэг шинээр орж ирсэн зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх;
5. Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх зэргийг шалгах;

¹ Хуулийн төслийн “Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийг “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийн зардлын тооцоо” сэдэвт судалгаа гүйцэтгэсэн байх тул дэлгэрэнгүйг тус судалгаанаас үзнэ үү.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авлаа. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд шинээр орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож үр нөлөө үнэлнэ.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөө тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт бүрээр тус бүрд нь авч үзье.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг.

Иймд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслөөс “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах зохицуулалтыг сонгож, үр нөлөөг тооцно. Үүнд:

Хүснэгт 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл заалт
1.	Хуулийн зорилт нь хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагад нийцэх эсэх.	Төслийн 1 дүгээр зүйл
2.	Хуулийн төслийн бүтэц, хамрах хүрээ нь хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагад нийцэх эсэх.	Хуулийн төсөл бүхэлдээ
3.	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих төрийн бодлого хуулийн төслийн зорилгод нийцэх эсэх.	Төслийн 43 дугаар зүйл
4.	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих төрийн байгууллагын тогтолцоо нь хуулийн төслийн зорилгод нийцэх эсэх.	Төслийн 44 дүгээр зүйл

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авдаг. Тус төслөөс “Практикт хэрэгжих боломж” шалгуурын үзүүлэлтийн хүрээнд дараах зохицуулалтыг сонгож, үр нөлөөг тооцсон болно.

Хүснэгт 2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, заалт
1.	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэх.	Төслийн 11-22 дугаар зүйл
2.	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэх.	Төслийн 23-42 дугаар зүйл
3.	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих байгууллагын тогтолцоотой холбоотой зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэх.	Төслийн 45-57 дугаар зүйл

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлнэ. Иймд тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд тус хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно.

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэх байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх учраас тодорхой байгууллага, иргэний эрх ашиг хөндөгдөж буй зохицуулалтыг сонгон авах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, тухайн төслөөр зохицуулж буй эсхүл шинээр оруулсан зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг үнэлэх учраас иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын эрх үүрэг, тэдгээрийн ашиг сонирхол хөндөгдөх зохицуулалтыг сонгосон болно.

**Хүснэгт 3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд
сонгосон зохицуулалт**

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Сонгосон зүйл, заалт
1.	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын ангилалтай холбоотой зохицуулалт хүлээн зөвшөөрөгдөх эсэх.	Төслийн 6 дугаар зүйл
2.	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээг эрт илрүүлэхтэй холбоотой зохицуулалт хүлээн зөвшөөрөгдөх эсэх.	Төслийн 58 дугаар зүйл
3.	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээтэй холбоотой зохицуулалт хүлээн зөвшөөрөгдөх эсэх.	Төслийн 59-65 дугаар зүйл
4.	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн сангийн зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх.	Төслийн 66-70 дугаар зүйл
5.	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой зохицуулалт хүлээн зөвшөөрөгдөх эсэх.	Төслийн 71 дүгээр зүйл
6.	Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг цуцалж, албадан гаргахтай холбоотой зохицуулалт хүлээн зөвшөөрөгдөх эсэх.	Төслийн 72 дугаар зүйл

2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учир хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгадаг. Иймд тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд тус хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно.

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тохирох шалгах хэрэгсэл нь урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрд нийцсэн дараах шалгах хэрэгслийн дагуу үнэлгээ өгөхөөр тогтлоо.

Хүснэгт 4. Тохирох шалгах хэрэгсэл

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
Практикт хэрэгжих боломж	Практикт турших
Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх
Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Өмнөх үе шатуудад журмын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтсон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 5. Тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг үнэлэх хэсэг

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Төслийн 1 дүгээр зүйл Төслийн 43 дугаар зүйл Төслийн 44 дүгээр зүйл	Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлал, хууль боловсруулах хэрэгцээ, шаардлага болон тус хуулийн хуулийн төслийн зорилт, холбогдох зохицуулалтын зорилго, үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх.
2.	Практикт хэрэгжих боломж	Төслийн 11-22 дугаар зүйл Төслийн 23-42 дугаар зүйл Төслийн 45-57 дүгээр зүйл	Практикт хэрэгжих байдлыг баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар хэрэгжих эсэхийг судлах.
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Тодорхойлоогүй нэр томъёонуудыг тайлбарлах байдлаар санал болгох, хуулийн төсөл боловсруулах нийтлэг шаардлагад нийцүүлэх саналыг гаргах.
4.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Төслийн 6 дугаар зүйл Төслийн 58 дугаар зүйл Төслийн 59-65 дугаар зүйл Төслийн 66-70 дугаар зүйл Төслийн 71 дүгээр зүйл	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх асуудлын хүрээнд баримт бичгийн судалгаа хийж дүгнэх.
5.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Харилцан уялдааг судлах, ингэхдээ холбогдох хуулийн зохицуулалтуудад дүн шинжилгээ хийх.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал”-ыг үнэлэхдээ хуулийн төсөл нь хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр хүрэх үр дүн тодорхой байдлаар томъёологдож чадсан эсэхийг тухайн хуулийн төсөл, дээд эрэмбийн хуулийн үзэл баримтлал, түүний агуулгыг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж буй зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийдэг. Энэ хүрээнд хуулийн төслийн 1, 43, 44 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг үнэллээ.

Хуулийн зорилт нь хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагад нийцэх эсэхэд хийсэн дүн шинжилгээ
--

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д тус хуулийн зорилтыг “...мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино...” гэж тодорхойлсон.

Тус хуулийн төслийн үзэл баримтлалд дурдагдсанаар хууль батлагдсаны дараа дараах эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагавар гаргахаар тусгажээ.


- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, түүний зорилт, хэрэгжүүлэх үндсэн зарчим тодорхой болно. Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдал хангагдаж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийт, ялангуяа хүүхэд, залуучуудад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаар таниулах эрх зүйн орчин боловсронгуй болно.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүх үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх журмыг хуульд тодорхой тусган, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хийдлийг арилган, үйл ажиллагаа явуулах нөхцөл, шаардлагыг тодорхой болгоно.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журмыг тодорхой болгож, энэхүү үйл ажиллагаанд эрэлч нохой болон орчин үеийн шаардлагад нийцсэн, өдөр тутам ашиглахад хялбар, найдвартай, өртөг зардал багатай тоног төхөөрөмжийг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдон шийтгүүлж байсан этгээд суллагдсаны дараа тодорхой хугацаанд хяналт тогтоох, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зохицуулалтыг бий болгоно.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, мансуурах донтой хүнд стандартад нийцсэн эрүүл мэнд, нийгэм хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, эмчлэх, хяналтад авах, нийгэмшүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах зохицуулалт бий болно.



- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг ялгамжтай тогтоож, ял шийтгэлийн бодлогыг чангаруулна.

- Нийтийн эрүүл мэндийг хамгаалах, мансуурах донг эмчлэх шинэ арга, ажиллагааны талаарх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж нэмэгдэнэ.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх арга хэмжээг оновчтой зохион байгуулах, үр дүнг үнэлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээнд тогтмол судалгаа, мониторинг хийх мэдээллийн нэгдсэн цахим сан бий болно.

- Мансууруулах эм худалдах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын зарцуулсан, худалдан борлуулсан эм, бэлдмэлийн тоо хэмжээ, зориулалтад хяналт тавих, тайлагнах журам хуульчлагдана.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг үйлдэгдсэн байдлыг судлан үзэж, гэмт этгээдэд хүлээлгэх хариуцлагыг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээ, үйлчлэл болон бусад объектив талыг харгалзан ялгамжтай тогтоож, ял шийтгэлийн бодлогыг чангаруулна.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоо буурч, тэдгээрийг таслан зогсоох ажилд ахиц, дэвшил гарах төдийгүй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх иргэдийн мэдлэг дээшилж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болон хамааралтай иргэдэд эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бүрдэнэ.²

Тус хуулийн зорилт нь дээрх хууль батлагдсаны дараа бий болох эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагаврыг бүхэлд нь оновчтой байдлаар тусгасан буюу хуулийн зорилгод нийцэж байна. Мөн одоо хэрэгжиж буй хуулийн зорилтын уламжлалт шинж чанарыг агуулсан байна.

2002 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зорилтыг "...мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино." гэж тодорхойлсон.

Одоогийн хуулийн зорилтод хүн амын удмын санг хамгаалах тусгаагүй байгаагаар ялгаатай байна. Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.1.3.4-т "...архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна" гэж зохицуулсан тул удмын санг хамгаалах талаар хуулийн зорилтод тусгах эсэхийг эргэн харах нь зүйтэй.

² Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, (УБ, 2024).

Хуулийн төслийн бүтэц, хамрах хүрээ нь хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагад нийцэх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Тус хуулийн төсөл нь:

- Нийтлэг үндэслэл
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, түүний угтвар бодис, ангилал, жагсаалт, эргэлт;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагаа ;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих төрийн бодлого, байгууллагын тогтолцоо;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээ;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн сан;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Бусад зүйл гэсэн 9 бүлгээс бүрдэж байна.


Тус хуулийн төслийн: Энэхүү бүлэг зохицуулалтуудыг хуулийн төслийн танилцуулгад дараах байдлаар агуулгыг авч үзсэн.

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томьёоны тодорхойлолт, ансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих үйл ажиллагаанд баримтлах зарчим;

Хоёрдугаар бүлэгт Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын угтвар бодис, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис болон түүний угтвар бодисын эргэлт, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт үйлчилгээтэй шинэ төрлийн бодис, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хуульд заасан эрх бүхий байгууллага чиг үүргийн хүрээнд ашиглах зориулалт;

Гуравдугаар бүлэгт Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага, Зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичиг, Зөвшөөрөл олгох, мэдэгдэх журам, Зөвшөөрлийн хугацаа, Зөвшөөрлийн хугацааг сунгасныг мэдэгдэх, Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, Зөвшөөрөл шилжүүлэхийг хориглох, Зөвшөөрлийг хүчингүй болгох, Зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагааны тайлан, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагааны тайланг хадгалах;

Дөрөвдүгээр бүлэгт Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлох, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэх, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис худалдах буюу ханган нийлүүлэх, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эмийн жор олгох, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эмийг эмийн сангаас олгох, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх, Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамал түүх, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг эрх бүхий байгууллага чиг



үүргийн хүрээнд ашиглах, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг зэвсэгт хүчинд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зориулалтаар ашиглах, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль сахиулах байгууллага сургалтын зориулалтаар ашиглах, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг шинжилгээний зориулалтаар ашиглах, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг эрдэм шинжилгээ, судалгааны зориулалтаар ашиглах, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын нөөцөд ашиглах, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан, мал, амьтны эм ашиглах, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хадгалах, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг устгах, Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамал устгах;

Тавдугаар бүлэгт Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих төрийн бодлого, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих төрийн байгууллагын тогтолцоо, Үндэсний хороо, түүний бүрэн эрх, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, Тагнуулын байгууллагын чиг үүрэг, Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, Хил хамгаалах байгууллагын чиг үүрэг, Гаалийн байгууллагын чиг үүрэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүрэг, Нутгийн удирдлагын байгууллагын чиг үүрэг;

Зургаадугаар бүлэгт Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээг эрт илрүүлэх, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнд тусламж, үйлчилгээ үзүүлэх, Эмийн болон сэтгэл заслын эмчилгээ, Донтох эмгэгийг нөхөн сэргээх эмчилгээ, Донтох эмгэгийг нөхөн сэргээх төв, Албадан эмчилгээ, Нийгмийн хамгааллын арга хэмжээ, Зан үйлд нөлөөлөх сургалт;

Долоодугаар бүлэгт Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн сан, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сангийн төрөл, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийн мэдээллийн сан, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн мэдээллийн сан, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болон хамааралтай хүнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний мэдээллийн сан;

Наймдугаар бүлэгт Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;

Есдүгээр бүлэгт Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг цуцалж, албадан гаргах, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлаас урьдчилан сэргийлэх, хууль бус эргэлттэй тэмцэх талаар хүн, хуулийн этгээдийн үүрэг, Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар³ тусгажээ.

³ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төсөл, (УБ, 2026).



Тус хуулийн төслийн бүлэг зохицуулалтууд нь хууль батлагдсаны дараа бий болох эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагаврыг бий болгохоор байгаа бөгөөд хуулиар зохицуулах харилцааг бүхэлд нь зохицуулсан байна.

Иймд хуулийн агуулга, хамрах хүрээ нь хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн гэж үзлээ.

Хуулийн төслийн 43 дугаар зүйлд заасан Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих төрийн бодлогын зохицуулалт нь хуулийн төслийн зорилгод нийцэх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 43 дугаар зүйлд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавихад төрөөс баримтлах бодлогыг тодорхойлсон бөгөөд үүнд:

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, шуурхай илрүүлэх, таслан зогсоож энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах (Төслийн 43.1.1.);
- Мансуурах, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар хэрэглэгчийн тоог бууруулах (Төслийн 43.1.2.);
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээ, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлыг эрт шатанд илрүүлэх (Төслийн 43.1.3.);
- Мансуурах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болон хамаарал бүхий хүнд эрүүл мэндийн болон сэтгэц-нийгмийн сэргээн засах, нийгмийн хамгааллын нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх (Төслийн 43.1.4.);
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбоотой бүх үйл ажиллагааг зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр явуулах (Төслийн 43.1.5.);
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг бүрэн хянах (Төслийн 43.1.6.) асуудлыг тусгажээ.

Хуулийн төслийн 43.1.1 - Урьдчилан сэргийлэх, шуурхай илрүүлэх, таслан зогсоох

Энэхүү заалт нь тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан "урьдчилан сэргийлэх" зорилттой нийцэж байна. Урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох гурван механизмын нэгдлийг нэг заалтад тусгасан нь бодлогын цогц хандлагын илэрхийлэл юм.

Хуулийн төслийн 43.1.4 - Эмнэлгийн болон сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж

Энэхүү бодлогын чиглэл нь НҮБ-ын Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай 1971 оны Конвенцийн 20 дугаар зүйлд заасан шаардлагад нийцэж байна. Засгийн газрын 2025 оны 29 дүгээр тогтоолд "олон улсын стандартад нийцсэн эрүүл мэндийн байгууллага байгуулах" заалт орсон нь бодлогын тасралтгүй байдлын илэрхийлэл юм.

Хуулийн төслийн 43.1.5 - Зөвшөөрөл, бүртгэлийн тогтолцоо

Хуулийн төслийн 11-22 дугаар зүйлд нарийвчлан тусгасан зөвшөөрлийн тогтолцоо нь 1961, 1971 оны конвенцуудын голлох шаардлага нь бодисын "зөвхөн эмнэлгийн болон шинжлэх ухааны зориулалтаар" хэрэглэх зохицуулалттай нийцнэ.

Хуулийн төслийн 43.1.6 - Бүрэн хяналт

Дөрвөн ангиллын тогтолцоо (А/Б/В/Г) нь дотоодын онцлогт нийцүүлсэн хяналтын дифференциал тогтолцоог бүрдүүлсэн байна. Энэхүү бодлогын чиглэл нь хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д заасан "эргэлтэд хяналт тавих" зорилттой нийцэж байна.

Бодлогын чиглэлүүдийн дэс дараалал нь олон улсын сайн туршлагатай нийцэж байна. Мөн урьдчилан сэргийлэх анхдагч (primary), эрт илрүүлэлт нь дагалдах (secondary), эмчилгээ нь гуравдагч (tertiary) шатны хөтөлбөрийн дарааллыг тусгасан байна.

Олон улсын сайн туршлагын хувьд мансуурах эм, сэтгэцэт нөлөөт бодисын хяналтын хуулинд нийтийн эрүүл мэндийн хандлагыг хяналт, шийтгэлийн хандлагатай тэнцвэржүүлэн тусгах нь илүү үр дүнтэй байдаг. Хуулийн төслийн 43 дугаар зүйл нь уг тэнцвэрийг тусгасан хэдий ч "хэрэглэгч" болон "хэрэгтэн" хоёрын ялгааг бодлогын хувьд тодорхойлоогүй байна.

Шинэ төрлийн мансууруулах бодисууд (New Psychoactive Substances – NPS) болон нийлэгжсэн мансуурах бодисын эргэлтэд хяналтад тавих талаар Хуулийн төслийн 43 дугаар зүйлд тусгайлан дурдагдаагүй байна. Монгол Улсын парламентын хороо 2025 оны тогтоолд "олон улсын гэрээнд ороогүй бодисыг жагсаалтад тогтмол шинэчлэн оруулах" гэж тусгаж өгсөн.

Мөн төрөөс баримтлах дээрх бодлого нь одоогийн баримталж буй бодлоготой нийцэлтэй байх ёстой. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх, хууль бус эргэлтэд хяналт тавих талаар Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр” хэрэгжиж байна. Тус хөтөлбөрийн зорилт, үр дүнг дараах байдлаар тодорхойлсон.

Хүснэгт 6. Зорилтын агуулга, үр дүн

Зорилт	Зорилтын агуулга	Зорилтын үр дүн
Зорилт 1.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр НҮБ-аас баталсан гэрээ, конвенцод Монгол Улс нэгдэн орж, дотоодын хууль тогтоомжийг Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцүүлэх замаар эрх зүйн орчин боловсронгуй болно. Ингэснээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий гадаад, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайжирна.
Зорилт 2.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтаар хангах, үйл ажиллагааны чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын уялдаа холбоог сайжруулах;	Мансууруулах эм, эд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох ажилд ахиц дэвшил гарч, гэмт хэрэг, зөрчлийн тоо буурна.

Зорилт 3.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах;	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх хүүхэд, залуучууд, иргэдийн мэдлэг дээшилж, донтсон болон хэрэглэгч болсон иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн болон нийгмийн тусламж үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бий болно. Ингэснээр нөхөн үржихүй болон хүн амын удмын санг хамгаалах, энэ төрлийн гэмт хэргийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл буурах нөхцөл бүрдэнэ.
Зорилт 4.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах, тэдгээрийг арилгах арга замыг оновчтой тодорхойлох;	Төрөөс баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагаас шинжлэх ухааны үндэслэлтэй хийсэн суурь болон хавсарга судалгааны дүнд суурилан төлөвлөж боловсруулдаг болно. Ингэснээр энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажил үр дүнтэй хэрэгжих нөхцөл бий болно.
Зорилт 5.	Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулах, эрүүл мэнд, шүүх эрх мэдлийн байгууллагуудын алба хаагчдыг мэргэшүүлж, орчин үеийн шинэ технологи нэвтрүүлэх	Төрийн байгууллагууд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг богино хугацаанд илрүүлэх, таслан зогсоох, шинжлэн судлах орчин үеийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдаж, алба хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилснээр энэ төрлийн гэмт хэргийг шуурхай илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд ахиц дэвшил гарна.

Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг 2023 онд үнэлж, хөтөлбөрийн зорилт бүрээр тусгайлсан дүгнэлтийг өгсөн.

Нэгдүгээр зорилт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох” 93.6 хувийн хамгийн өндөр биелэлттэй байна. Энэхүү зорилтын хүрээнд 9 үйл ажиллагаа авч хэрэгжүүлсний 3 нь үр дүнтэй, 6 нь тодорхой үр дүнтэй байна. Олон улсын геополитикийн нөхцөл байдлаас хамаарч аливаа гэмт хэргийн хэлбэр, нөхцөл байдал хувьсан өөрчлөгдөж байна. Иймд иргэдийн зорчих хөдөлгөөн, гэмт хэрэгт өртөх, оролцох магадлалд үндэслэн. харилцан туслалцаа үзүүлэх улс хоорондын гэрээг шинэчлэх, өргөжүүлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай.

Хоёрдугаар зорилт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтаар хангах, үйл ажиллагааны чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын уялдаа холбоог сайжруулах” 87.0 хувийн биелэлттэй. Дээрх зорилтын хүрээнд 6 үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн бөгөөд үр дүнтэй 1, тодорхой үр дүнтэй 4, эрчимжүүлэх шаардлагатай 1 үйл ажиллагаа байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүрэг бүхий албан хаагчдын нийгмийн баталгаа, аюулгүй байдал байгууллага тус бүрийн үндсэн чиг үүрэг, дотоод бүтэц, зохион



байгуулалтаас хамаарч харилцан адилгүй байна. Тухайлбал, цагдаагийн байгууллага болон Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй ажилтан албан хаагчдын тогтвортой байдал, нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.


Гуравдугаар зорилт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах” 84.4 хувийн биелэлттэй байна. Зорилтын хүрээнд 13 үйл ажиллагаа хэрэгжүүлснээс үр дүнтэй 5, тодорхой үр дүнтэй 8 үйл ажиллагаа байна. Энэхүү зорилтын үйл ажиллагаа бүрэн хангахын тулд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, хөтөлбөрийг сурталчлах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг харуулсан урлагийн бүтээл, нийтлэл, нэвтрүүлгийн тоог нэмэгдүүлэх, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр хар тамхи, мансууруулах төрлийн бодис хэрэглэх, бэлтгэх, борлуулах, хэрэглэх аргачлалыг харуулсан, уриалан дуудсан сөрөг сурталчилгаа хийхийг хориглох, хариуцлага оногдуулах эрх зүйн орчныг бий болгох зэрэг үйл ажиллагаанд анхаарч ажиллах хэрэгтэй.

Дөрөвдүгээр зорилт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах, тэдгээрийг арилгах арга замыг оновчтой тодорхойлох” 77.6 хувийн биелэлттэй байна. Тус зорилтын хүрээнд 5 үйл ажиллагаа авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд үр дүнтэй 1, тодорхой үр дүнтэй 2, эрчимжүүлэх шаардлагатай 2 үйл ажиллагаа байна. Цаашид байгууллага хооронд ашиглах мэдээллийн нэгдсэн санг бий болгох, салбар зөвлөлүүд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх төвийг байгуулах тогтмол ажиллуулах нөхцөлийг бий болгох чиглэлд анхаарах хэрэгтэй байна.

Тавдугаар зорилт “Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулах, эрүүл мэнд, шүүх эрх мэдлийн байгууллагуудын алба хаагчдыг мэргэшүүлж, орчин үеийн шинэ технологи нэвтрүүлэх” 88.1 хувийн биелэлттэй байна. Энэхүү зорилтын хүрээнд 8 үйл ажиллагаа авч хэрэгжүүлсний 4 нь үр дүнтэй, 2 нь тодорхой үр дүнтэй, 2 нь эрчимжүүлэх шаардлагатай байна. Цаашид мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх нохойн сургалтын төв байгуулах, сэжиг бүхий этгээдээс мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг илрүүлэх багаж хэрэгслээр (анхан шатны) замын болон хэв журмын цагдаа, яаралтай түргэн тусламжийн эмч, хил хамгаалах, гаалийн байгууллагын алба хаагчдыг хангах чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай байна⁴.

Дээрхээс дүгнэвэл, хуулийн төсөлд тусгасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх зорилгоор төрөөс баримтлах бодлого нь “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-тэй нийцэж байна. Гэвч тухайн төрөөс баримтлах бодлогыг тодорхойлохдоо зарим бодлогыг нарийвчилж тодорхойлоогүй байна. Түүнчлэн хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг бүхэлд нь нарийвчлан тодорхойлсон төрөөс баримтлах

⁴ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, “Эс Ай Си Эй” ХХК, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ”, (УБ, 2023), 75-76 дахь тал.



бодлогыг тодорхойлох нь зүйтэй. Иймд төрөөс баримтлах бодлогыг өргөн хүрээнд тодорхойлж, нарийвчлан тусгах талаар анхаарах шаардлагатай.

Хуулийн төслийн 44 дүгээр зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих төрийн байгууллагын тогтолцооны зохицуулалт нь хуулийн төслийн зорилгод нийцэх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 44 дүгээр зүйлд бүрдүүлсэн байгууллагын тогтолцоо нь Монгол Улсын засаг захиргааны бүтэцтэй нийцсэн дөрвөн шатлалт тогтолцоог бүрдүүлж өгсөн байна.

Хуулийн төслийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэгт Засгийн газрын 8 чиглэлт бүрэн эрхийг нарийвчлан тусгасан байна. Эдгээрийг хуулийн зорилтын хүрээнд дараах байдлаар үнэлж болно:

Хуулийн төслийн 44.3.1. Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах

Засгийн газарт хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах бүрэн эрх олгосон энэхүү заалт нь хуулийн хэрэгжүүлэгч байгууллагын тогтолцооны эрх зүйн суурийг тавьж байна. Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах бүрэн эрхийг Засгийн газарт олгосон нь институцийн тогтвортой байдлыг хангах чухал алхам юм. Өмнө нь Засгийн газрын тогтоолоор байгуулагддаг байсан Үндэсний хорооны эрх зүйн байдлыг хуульд тусгасан нь удирдлагын тасралтгүй байдал, бодлогын уялдаа холбоог хангахад чухал ач холбогдолтой.

Хуулийн төслийн 44.3.2. Техник, тоног төхөөрөмжийн хангамж

Хяналтын лаборатори, хилийн хяналтын тоног төхөөрөмжийн хангамжийн хүрэлцээтэй байдал нь хяналтын үр нөлөөг шууд тодорхойлно. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-ны 2024 оны Зүүн Ази, Номхон далайн бүсийн үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн үнэлгээний тайланд лабораторийн чадавхийн дутагдал, шүүх эмнэлгийн мэргэжилтнүүдийн хомсдол нь мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг үр дүнтэй шалган шийдвэрлэхэд саад болж байгааг онцлон тэмдэглэсэн байдаг.⁵

Засгийн газар 2024 оны 5 дугаар сараас эхлэн UNODC-тай хамтран Монгол Улсын Хууль сахиулах сургалтын санаачилга (Mongolia Law Enforcement Training - M-LET)-ыг хэрэгжүүлж эхэлсэн нь хуулийн төслийн 44.3.2 дахь бүрэн эрхийн практик хэрэгжилтийн анхны алхам болж байна. Уг санаачилга нь техникийн туслалцаа, тоног төхөөрөмжийн хангамж, мэргэжилтэн бэлтгэх зэрэг цогц арга хэмжээг хамарч байна.

Хуулийн төслийн 44.3.3. Хүний нөөцийн мэргэшүүлэлт

UNODC-ийн M-LET зорилтод "Хууль зүйн, Дотоод хэргийн их сургуулийн багш нар, Авлигатай тэмцэх газрын мэргэжилтнүүд, Цагдаагийн ерөнхий газрын ажилтнуудыг сургагч багшаар бэлтгэх"⁶ гэж заасан нь хуулийн төслийн 44 дүгээр зүйлийн 44.3.3 дахь заалттай нийцэж байна.

⁵ UNODC, "Transnational Organized Crime in East Asia and the Pacific: A Threat Assessment", 2024, p. 45-52.

⁶ UNODC, Mongolia and UNODC launch initiative to combat transnational organized crime, UNODC ROSEAP [//www.unodc.org/roseap/en/2024/05/mongolia-transnational-organized-crime/story.html](https://www.unodc.org/roseap/en/2024/05/mongolia-transnational-organized-crime/story.html)



Энэхүү хандлага нь "сургагч багш бэлтгэх" (train-the-trainer) загварыг ашиглан хоёрдогч түвшний сургалтын тогтолцоо бий болгох боломжийг нээж байна.

Хуулийн төслийн 44.3.4. Лабораторийн чадавхийг бэхжүүлэх

Мансууруулах бодисын шинжилгээний лабораторийн чадавхи нь гэмт хэргийг нотлох, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны үр нөлөөтэй шууд холбоотой. UNODC-ийн 2024 оны Дэлхийн мансууруулах бодисын тайланд синтетик мансууруулах бодисын төрөл, найрлага тасралтгүй өөрчлөгдөж байгаа нь лабораторийн чадавхийг байнга шинэчлэх шаардлагатайг онцолсон байна.⁷

Хуулийн төслийн 44.3.5. Төрийн бус байгууллагын дэмжлэг

Мансууруулах бодисын асуудлыг шийдвэрлэхэд иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг нь олон улсын сайн туршлагаар баталгаажсан. "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр" (2017)-ийн Зорилт 3-т *"иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээллээр хангах"* талаар төрийн бус байгууллагуудын оролцоог дэмжихээр заасан байна.⁸

UNODC-ийн "Мансууруулах бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх олон улсын стандарт" (2018)-д төрийн бус байгууллагууд нь урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, донтолтоос сэргийлсэн иргэдэд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зэрэг чиглэлээр чухал үүрэг гүйцэтгэдгийг онцолсон байна.⁹ Хуулийн төслийн 44.3.5 дахь заалт нь эдгээр олон улсын зөвлөмжийг дотоодын хуулиар хэрэгжүүлэх эрх зүйн суурийг бүрдүүлж байна.

Хуулийн төслийн 44.3.6. Мэдээллийн нэгдсэн систем

Мэдээллийн нэгдсэн систем нь нотолгоонд суурилсан бодлого боловсруулах үндэс суурь болдог. Монгол Улс нь Нээлттэй Засгийн газрын түншлэл (Open Government Partnership - OGP)-ийн 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд *"Эмийн хяналт, мэдээллийн цахим системийг сайжруулах"* үүрэг амлалтыг хүлээсэн нь 44.3.6 дахь бүрэн эрхтэй шууд уялдаж байна.¹⁰

Мэдээллийн нэгдсэн систем байгуулснаар байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулах, давхардсан мэдээллийг арилгах, бодлогын шийдвэр гаргахад шаардлагатай статистик мэдээллийг цаг тухайд нь гаргах боломж бүрдэнэ.

Хуулийн төслийн 44.3.7. Санхүүжилт, олон улсын хамтын ажиллагаа, нутгийн удирдлагын оролцоо

Хуулийн төслийн 44.3.7 дахь санхүүжилтийн заалт нь Үндэсний хөтөлбөрийн *"санхүүжилт нь улсын төсөв, олон улсын тусламж, хандиваас бүрдэнэ"* гэсэн зарчимтай бүрэн нийцэж байна. Энэ нь хуулийн хэрэгжилтийг санхүүгийн хувьд баталгаажуулах эрх зүйн үндэс болж байна.

⁷ UNODC, World Drug Report 2024, United Nations publication (Vienna: UNODC, 2024). Эх сурвалж: <https://www.unodc.org/unodc/data-and-analysis/world-drug-report-2024.html>

⁸ "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр", Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоол, Зорилт 3.

⁹ UNODC, "International Standards on Drug Use Prevention", Second Updated Edition, 2018, p. 23-31.

¹⁰ Open Government Partnership (OGP), Mongolia Action Plan 2024-2028, Commitment 4: Strengthening Drug Control Information Systems.



Хуулийн төслийн 1, 43, 44 дүгээр зүйлийн зохицуулалт нь хуулийн нэгдүгээр зүйлд тодорхойлсон зорилготой үндсэн агуулгын хувьд нийцэж байна. Эдгээр зүйл, заалт нь НҮБ-ын Мансууруулах бодисын тухай 1961 оны конвенц, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенц, Мансууруулах бодис ба сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг 1988 оны конвенцоор хүлээсэн үүргүүдтэй уялдаж байна.

Мөн 2017 оны Үндэсний хөтөлбөр болон Засгийн газрын 2025 оны 29 дүгээр тогтоолын чиглэлийг дотоодын хуулиар хэрэгжүүлэх эрх зүйн суурийг бүрдүүлж байна. Тухайлбал, Хуулийн төслийн 43 дугаар зүйлийн зургаан бодлогын чиглэл нь урьдчилан сэргийлэхээс эхлэн эмчилгээ, хяналт хүртэлх бүрэн дэс дарааллыг хамарч байна. мөн хуулийн төслийн 44 дүгээр зүйлийн байгууллагын тогтолцоо нь хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх яам, агентлагийг хамруулсан олон талт хяналтын тогтолцоог бүрдүүлж байна.

Гэвч хуулийн төслийн 43, 44 дүгээр зүйлийн хэрэгжилтийн механизм, хугацааны тодорхойлолт, байгууллага хоорондын уялдааны нарийвчилсан зохицуулалтын талаар дагалдах захиргааны актуудаар нөхөн зохицуулах шаардлагатай байна. Үүнд: бүрэн эрх тус бүрийн хэрэгжилтийн хугацааг тодорхойлсон Засгийн газрын тогтоол; байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам; хяналт-шинжилгээ, үнэлгээний журам; тандалт судалгааны арга зүй, давтамжийг тогтоосон журам зэргийг батлах шаардлагатай.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн төслийн зохицуулалт нь тодорхой тохиолдолд үйлчлэх, бодит байдал дээр хэрэгжих эсэхийг үнэлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 1/ 11-22 дугаар зүйлд заасан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой зохицуулалт, 2/ хуулийн төслийн 23-42 дугаар зүйлд заасан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт, 3/ хуулийн төслийн 45-57 дугаар зүйлд заасан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих байгууллагын тогтолцоотой холбоотой зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн 11-22 дугаар зүйлд заасан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 11-22 дугаар зүйл нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын тусгай зөвшөөрөл (11-14 дүгээр зүйл) болон импорт, экспорт, дамжин өнгөрүүлэх (15-22 дугаар зүйл) харилцааг зохицуулж байна. Эдгээр зүйлүүд нь хуулийн төслийн "хууль ёсны эргэлтэд хяналт тавих" болон "хууль бус эргэлттэй тэмцэх" гэсэн хоёр зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.


Одоогийн эрх зүйн зохицуулалтын тухайд Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/408 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, экспортлох, хадгалах, устгах, түгээх, худалдах үйл ажиллагааг зохицуулах журам”/цаашид “Журам” гэх/-аар зохицуулж байна.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт зөвшөөрөл шаардагдах найман төрлийн үйл ажиллагааг тодорхойлжээ. Тухайлбал:

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис импортлох, реэкспортлох;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис экспортлох,
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис худалдах буюу ханган нийлүүлэх;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эм олгох эмийн сангийн үйлчилгээ эрхлэх;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж эмээр үйлчлэх;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг судалгаа шинжилгээний зориулалтаар түүх зэрэг хамаарна.

Харин журмаар аж ахуйн тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааны жагсаалтыг тодорхойлсон байдаг¹¹ бөгөөд хуулийн төсөлд энэхүү жагсаалтыг баталгаажуулж, хуульчилсан байх тул хэрэгжих боломжтой гэж үзэж байна. Гэхдээ хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.7-д заасан мансууруулах, сэтгэцэд нөлөөт

¹¹ Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/408 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, экспортлох, хадгалах, устгах, түгээх, худалдах үйл ажиллагааг зохицуулах журам”



бодис агуулсан ургамлыг "судалгаа, шинжилгээний зориулалтаар түүх" зөвшөөрлийн зохицуулалт ямар субъектын хяналтан дор, ямар журмаар, ямар газарт түүх талаар нарийвчлан тусгаагүй нь практикт хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж болзошгүй.

Мөн хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэгт зөвшөөрөл эзэмшигч нь дараа онд үйлдвэрлэх, импортлох, экспортлох, түүх мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийг тухайн оны эхний хагас жилд багтаан эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон цагдаагийн төв байгууллагад хүргүүлэхийг шаардаж байна. Энэ нь цагдаагийн байгууллагын ачааллыг нэмэгдүүлж, зөвшөөрөл эзэмшигчид хүндрэл учруулж болзошгүй. Иймд нэгдсэн цахим мэдээллийн системтэй болгосон тохиолдолд уг асуудлыг шийдвэрлэж болохыг анхаарах нь зүйтэй.

Харин хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт зөвшөөрлийг зөвхөн хуулийн этгээдэд олгохоор тогтоосон нь оновчтой зохицуулалт болсон байна. Мөн зүйлийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн зохицуулалтад 7 үндэслэл тусгасан байх бөгөөд эдгээр үндэслэлийг практикт хэрэгжүүлэхэд дараах асуудал үүсэх эрсдэлтэй байна. Үүнд:

- Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.2.2-д *"мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх талаар ажилтнуудыг тогтмол сургаж, дадлагажуулах төлөвлөгөөтэй байх"* гэсэн шаардлагыг тусгажээ. Энэ нь зарчмын хувьд зүйтэй боловч "тогтмол" гэсэн нэр томьёо хэр давтамжтай байхыг (жилд нэг удаа эсхүл улирал тутам гэх мэтчилэн) тодорхойлоогүй нь практикт нэгдмэл биш ойлголт үүсгэж, хяналт тавих боломжийг бууруулж байна.
- Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.2.5-д *"зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг хуульд заасны дагуу явуулах нөхцөл, шаардлагыг хангасан барилга байгууламж, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай техник хэрэгсэлтэй байх"* гэж заасан байна. Гэвч "шаардлагатай техник хэрэгсэл" гэдэг ойлголтыг тодорхойлоогүй нь зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын хувьд тухайн ойлголтыг өргөн хүрээнд тайлбарлан хэрэглэх боломжийг бүрдүүлсэн байна.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлд зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичгийн бүрдлийг гурван түвшинд тусгасан байна: нийтлэг (13.1), үйлдвэрлэлд зориулалттай нэмэлт (13.2), импорт, экспорт, реэкспортод зориулалттай нэмэлт (13.3).

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн угтвар бодисын импортлох тусгай зөвшөөрлийг 2022 оны байдлаар "Азифарм, Еврофарм, ЭНТО, Чигатуссин, Моносфарм трейд, Монгол эм импекс концерн, Монос трейд" ХХК гэсэн 7 байгууллага, үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг "Айвико, Монос Фарм" ХХК-ууд авсан ба Монгол Улсын дээрх жагсаалтад заасан 14 нэрийн мансууруулах эм, 35 нэрийн сэтгэцэд нөлөөт эмийг импортолж байна.

Нийтлэг баримт бичгийн жагсаалт (13.1) нь Журмын 2.3-т тусгасан баримт бичгийн шаардлагатай харьцангуй нийцэж байх бөгөөд одоогийн практиктай адил буюу зохисгүй нэмэлт шаардлага тусгаагүй нь хэрэгжих боломжтой болохыг илэрхийлж байна.

Түүнчлэн, хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д *"мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис бүхий хүнд зориулсан эм, эмийн түүхий эдийг хадгалах агуулах нь*



стандартын шаардлага хангасан эсэх талаарх ... хяналтын улсын байцаагчийн дүгнэлт" гэж заажээ. Одоогоор практикт байгууллагын агуулахын стандарт шаардлагыг тодорхойлсон баримт бичиг нь Засгийн газрын тусгай тогтоол болон Эрүүл мэндийн сайдын баталсан журмаар зохицуулагддаг бөгөөд зөвшөөрлийн хүсэлт бүрд улсын байцаагчаар дүгнэлт гаргуулах шаардлага нь байцаагчийн ачааллыг нэмэгдүүлж, нөөц хүрэлцэхгүй болох эрсдэлтэй. Олон улсад зөвшөөрлийн хугацаанд тогтмол хяналтын дүгнэлт гаргуулах биш анхны зөвшөөрөл олгохоос өмнөх шалгалтад л шаарддаг жишиг түгээмэл байдаг.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт үйлдвэрлэлийн зөвшөөрлийн нэмэлт баримт бичгийн хүрээнд *"нэг жилд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис бүхий эм, эмийн түүхий эд үйлдвэрлэх хүчин чадал, төлөвлөгөөг мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис бүхий эм, эмийн түүхий эдийн нэр, тун, хэлбэр, тоо, хэмжээгээр илэрхийлсэн мэдээлэл"* шаардахаар заасан байна. Монгол Улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис бүхий эм үйлдвэрлэдэг байгууллага одоогоор хязгаарлагдмал байдаг тул энэхүү шаардлага практикт хэрэгжих боломжтой гэж үзэж байна.


Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг нь зөвшөөрлийн хугацааг Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хугацааны дагуу шийдвэрлэхийг заасан байна. Зөвшөөрлийн тухай хуульд ерөнхий зохицуулалт тусгагдсан боловч мансууруулах эмийн зөвшөөрлийн хувьд тусгай хугацааг тодорхойлоогүй нь аль хугацааг баримтлах нь тодорхойгүй болгодог.

Мөн зүйлийн 14.2 дахь хэсэгт зөвшөөрөл олгосноос хойш ажлын гурван өдрийн дотор цагдаагийн төв байгууллагад мэдэгдэх үүргийг тусгажээ. Журамд энэ мэдэгдлийн хугацааг 7 хоног гэж тогтоосон байсан боловч тус хуулийн төсөлд энэ хугацааг богиносгосон нь зарим тохиолдолд захиргааны ачааллыг нэмэгдүүлэх боловч мэдээллийн урсгалыг хурдасгах давуу талтай. Иймд энэхүү зохицуулалтыг практикт хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт *"...11.1.2-т зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар олгох..."*-оор тусгажээ. Таван жилийн хугацаа нь олон улсад нийтлэг хэрэглэгддэг бөгөөд байгууллагын тогтвортой үйл ажиллагаа явуулахад хангалттай урт хугацаа гэж үзэж болно. Иймд төслийн энэхүү зохицуулалт практикт хэрэгжих боломжтой байна.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт импортлох, экспортлох, реэкспортлохтой холбогдох зөвшөөрлийн загвар, агуулгыг нарийвчлан заасан нь тухайн зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд чухал үр нөлөөтэй. Тухайлбал, зөвшөөрөлд дугаар, олгосон огноо, олгосон эрх бүхий байгууллагын нэр, хаяг, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, тоо хэмжээ, хэлбэр, экспортлогч болон импортлогчийн нэр, хаяг болон хийсэн байх хугацаа зэргийг тусгахаар заасан байна. Журмын 2.7-д мансууруулах эмийн импорт, экспортын мэдүүлгийг шар, сэтгэцэд нөлөөт эмийнхийг ногоон өнгийн А4 цаасан дээр 5 хувь үйлдэж, тодорхой байгууллагуудад тараахаар заасан тул хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд нэг мэдүүлгийн тоо хувийг цөөлж, цахимжуулан илүү хялбар болгох боломжтой.

Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зөвшөөрлийн хугацааг хэрхэн сунгах, сунгах шаардлагыг хэн хүсэх, сунгах урьдчилсан нөхцөлийн талаарх мэдээллийг тусгаагүй байна. Зөвшөөрлийн тухай хуульд ерөнхий зохицуулалт тусгагдах боловч



мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодисын онцлогт тохирсон нарийвчилсан журам хэрэгтэй.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт зөвшөөрлийг түдгэлзүүлэх нэмэлт үндэслэл болгон "мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавих боломжгүй болсон нь хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдол"-д тавьжээ. Энэхүү зохицуулалт нь зарчмын хувьд оновчтой боловч "хяналт тавих боломжгүй болсон" гэдгийг тодорхойлох шалгуурыг тогтоогоогүй нь тухайн зохицуулалтыг өөр өөрөөр ойлгон хэрэглэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдуулах эрсдэлтэй.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт "зөрчлийг арилгах хүртэл" түдгэлзүүлэх, зөрчлийг арилгасан тохиолдолд сэргээхээр заасан нь практикт хугацааны хязгаарлалтгүй тул зөвшөөрөл эзэмшигч хязгааргүй хугацаагаар үйл ажиллагаа явуулах боломжгүй болох эрсдэлтэй. Европын холбооны зарим улсын практикт түдгэлзүүлсэн хугацааны дээд хязгаарыг тогтоодог¹² бөгөөд ийм хязгаарлалт нь хэрэгжих боломж, тогтвортой байдалтай зохицуулалтын чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт түдгэлзүүлсэн, сэргээсэн шийдвэрийг ажлын нэг өдрийн дотор цагдаагийн төв байгууллагад хүргүүлэхийг шаардсан байна. Нэг хоногийн хугацаа нь цахим тогтолцоонд оновчтой боловч цаасан баримт бичгийн эргэлт давамгайлдаг одоогийн нөхцөлд хэрэгжихэд хүндрэлтэй.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт зөвшөөрлийг зарах, бэлэглэх, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхийг хориглосон нь олон улсын жишигт нийцэж байна.


Харин хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.3 дахь хэсэгт хуулийн этгээдийн эзэмшил шилжсэн буюу өөрчлөн байгуулагдсан тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгон шинээр зөвшөөрөл авах шаардлага тавьжээ. Энэ практикт хэрэгжих боломжтой боловч шилжилтийн үе буюу өөрчлөн байгуулалтын явцад үйл ажиллагааг түр зогсоох нь эрүүл мэндийн байгууллагуудад эм хангамжийн тасалдлыг бий болгох эрсдэлтэй. Ийм тохиолдолд шилжилтийн хугацааны тусгай зохицуулалтыг хуульд тусгах нь чухал.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт зөвшөөрлийг хүчингүй болгох 5 үндэслэлийг тогтоожээ. Эдгээрийн дотроос 19.1.5 дахь заалтад *"зөвшөөрлийг нь нэг жилийн хугацаанд 3 удаа хуульд заасны дагуу түдгэлзүүлсэн"* тохиолдолд хүчингүй болгохоор заасан нь практикт хэрэгжих боломжтой, үр нөлөөтэй зохицуулалт байна.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтад *"мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулж хариуцлага хүлээсэн"* тохиолдолд хүчингүй болгохоор заасан байна. Тус зохицуулалтад заасан "хариуцлага хүлээсэн" гэдэгт эрүүгийн хариуцлага, зөрчлийн хариуцлага аль аль нь хамаарах эсэхийг тодорхой заагаагүй нь практикт тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэх эрсдэлтэй.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3 дахь хэсэгт ажлын нэг өдрийн дотор цагдаагийн байгууллагад мэдэгдэх үүрэгтэй гэж заажээ. Энэхүү зохицуулалт нь

¹² Жишээ нь: Европын Холбооны Directive 2001/83/EC болон холбогдох хэрэгжилтийн дүрмүүд нь зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд дээд хугацааны хязгаар тогтоодог.



төслийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт дурдсантай ижил, цахимжаагүй нөхцөлд нэг өдрийн хугацаа хэрэгжих боломжийн хязгаарлагдмал байна.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт зөвшөөрөл эзэмшигчид арван хоёр төрлийн үүрэг хүлээлгэсэн байна. Эдгээрийн ихэнх нь Журамд тусгагдсан шаардлагатай нийцэж байгаа тул хэрэгжих боломжтой байна.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис "дутсан, үрэгдсэн, илүүдсэн, эсхүл бүртгэлтэй холбоотой зөрчил гарсан" тохиолдолд цагдаагийн байгууллагад "нэн даруй" мэдэгдэхийг шаардсан байна. "Нэн даруй" гэдэг нэр томьёо нь хэдэн цаг, хэдэн өдрийг хэлж байгааг тодорхойлоогүй нь хэрэгжилтийн нэгдмэл бус байдалд хүргэж болно. Журамд "тухай бүр" буюу нэн даруй мэдэгдэх тухай заасан хэдий ч хугацааны хязгаар нарийвчлагдаагүй байгааг тус хуулийн төсөлд ч нарийвчлан тусгаагүй юм.

Мөн зүйлийн 20.1.5, 20.1.6-д үйлдвэрлэгч, импортлогч, худалдагч зөвшөөрөл эзэмшигч нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг "зөвхөн хуульд заасан зөвшөөрөл болон хуульд заасан ашиглах эрх бүхий этгээдэд" нийлүүлэх, тээвэрлүүлэх үүрэг хүлээхээр тусгасан байна. Энэ нь Журмын 3.3 дахь хэсэгт "зөвхөн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм импортлох-ханган нийлүүлэх, худалдах тусгай зөвшөөрөлтэй байгууллагад нийлүүлнэ" гэж тусгасантай нийцэж байна.


Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт зөвшөөрөл эзэмшигч нь эргэлтэд оруулсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, тун, хэлбэр, цувралын дугаар, тоо хэмжээ болон зарцуулалтын нарийвчилсан тайланг бодис бүрээр, улирал тутам гаргаж, хоёр байгууллагад (цагдаагийн төв байгууллага болон зөвшөөрөл олгосон байгууллагад) хүргүүлэхийг шаардаж байна.

Одоогийн Журамд тайланг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нэгтгэж дараа нь цагдаагийн байгууллага болон эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлдэг шат дараат тогтолцоотой байна. Хуулийн төсөлд зөвшөөрөл эзэмшигч шууд хоёр байгууллагад хандах тул нэгдмэл цахим тайлангийн системгүй бол хэрэгжилтийн хугацааны зардал нэмэгдэх дутагдалтай байна.

Харин тус зүйлийн 21.2 дахь хэсэгт цагдаагийн төв байгууллага улсын хэмжээнд нэгтгэсэн тайланг хэлэлцэхээр Үндэсний хороонд хүргүүлэх тогтолцоог бий болгосон нь стратегийн шийдвэр гаргалтад үр нөлөөтэй. Гэвч цагдаагийн байгууллагад аналитик болон нэгтгэх чиг үүрэг нэмэгдэж байгаа нь тэр байгууллагын хүний нөөц, мэргэшлийн хангалттай байдалд тулгуурладаг тул чадавхийг бэхжүүлэх шаардлагатай.

Мөн зүйлийн 21.3 дахь хэсэгт тайлангийн маягтыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан нь Журамд тусгасан хоёрдугаар хавсралтаар маягтыг тусгасантай нийцэж, практикт маягт батлах эрх мэдлийг тодорхойлж байгаа тул хэрэгжих боломжтой байна.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт тайланг 20 жилийн хугацаагаар хадгалах шаардлага тавьжээ. Харин журмын 4.7 дахь хэсэгт эмийн сангийн бүртгэлийг 1 жил хадгалж байгууллагын архивт шилжүүлэхийг заасан бол хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.6.5-д эрүүл мэндийн байгууллагын бүртгэлийг 5 жил хадгалж архивт шилжүүлэхийг заасан байна. Иймд хуулийн төсөлд нэмэлтээр тавигдсан 20 жилийн хадгалах хугацаа нь Журмын зохицуулалтаас ялгаатай байна.



20 жилийн хугацаа нь мансуурах эмийн ноцтой байдлыг харгалзан олон улсын практикт нийтлэг хэрэглэгддэг. Гэхдээ практикт хэрэгжих боломжийн тал дээр байгууллагуудын архивын нөөц, цахим болон цаасан хэлбэрийн аль алинд хадгалах хүчин чадал нь асуудал үүсгэж болохоор байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийн 11-22 дугаар зүйлийн зохицуулалт нь одоогийн журмын зохицуулалт болон практикт хэрэгжилтэд үндэслэж, тусгай зөвшөөрлийн тогтолцоог хуульчилсан байх тул тус зохицуулалтууд практикт хэрэгжих боломжтой байна. Гэвч дараах зохицуулалтуудыг нягтлан үзэж, боловсронгуй болгох шаардлагатай байна. Үүнд:

Нэгдүгээрт, зарим нэр томьёо болон хугацааны тодорхойлолт нь хэрэгжилтийн нэгдмэл бус байдалд хүргэх эрсдэлтэй байна. Тухайлбал, "Нэн даруй", "тогтмол сургах", "шаардлагатай техник хэрэгсэл" гэх мэт.

Хоёрдугаарт, хуулийн төсөлд тусгасан тайлагналын давхар үүрэг болон хэд хэдэн байгууллагад нэгэн зэрэг мэдэгдэх шаардлага нь нэгдсэн цахим мэдээллийн системгүй бол хэрэгжилтийн зардал, ачааллыг нэмэгдүүлнэ. Хуулийн төслийн 66-70 дугаар зүйлд мэдээллийн нэгдсэн санг заасан нь энэ асуудлыг шийдэх боловч хуулийн хэрэгжилтэд мэдээллийн системийн бэлэн байдал нөлөөлдөг учир цаг хугацааны уялдааг сайтар тооцох хэрэгтэй.

Гуравдугаарт, зөвшөөрлийн бүртгэл, мэдэгдэл, тайлангийн мэдэгдлийн хугацаа нь цахим тогтолцоонд боломжийн боловч шилжилтийн үед буюу цахимжуулалт бэлэн болоогүй нөхцөлд хэрэгжихэд хүндрэлтэй байж болно.

Хуулийн төслийн 23-42 дугаар зүйлд заасан Мансууруулах, сэтгэцэт нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 23 дугаар зүйлд мансууруулах, сэтгэцэт нөлөөт бодис үйлдвэрлэх үйл ажиллагааг хуулийн 11.1.1-д заасан зөвшөөрлийн үндсэн дээр, зөвхөн Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсон бодисыг хүн, мал, амьтанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зориулалтаар үйлдвэрлэхээр тусгажээ.

Практикт хэрэгжих боломжийн хувьд, Монгол Улсад мансууруулах, сэтгэцэт нөлөөт бодис агуулсан эм үйлдвэрлэх чадавх хязгаарлагдмал байна. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд эмийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлагыг тусгасан¹³ бөгөөд мансууруулах, сэтгэцэт нөлөөт бодис үйлдвэрлэх нь тусгай нөхцөл, хяналтын тогтолцоо, өндөр хүчин чадалтай лаборатори шаарддаг. Хуулийн төслийн 23.3-т зөвшөөрөл эзэмшигч нь үйлдвэрлэсэн бодисын орц, найрлагыг магадлан итгэмжлэгдсэн лабораториор жилд нэг удаа шинжлүүлэхээр заасан нь хэрэгжүүлэх бүрэн боломжтой зохицуулалт юм. Гэвч шаардлага хангахуйц, магадлан итгэмжлэгдсэн лаборатори Монгол Улсад хүрэлцээтэй байгаа эсэхийг судлан үзэх нь зүйтэй.

Мөн хуулийн төслийн 23.1-д зааснаар зөвшөөрөлгүйгээр болон эм, эмийн түүхий эдийн бүртгэлд ороогүй бодис үйлдвэрлэхийг хориглосон нь одоогийн хуулийн зохицуулалттай үндсэндээ нийцсэн, хэрэгжүүлэх этгээд тодорхой (зөвшөөрөл олгогч байгууллага, хяналтын улсын байцаагч нар) тул практикт хэрэгжих боломжтой гэж дүгнэж байна.

Хуулийн төслийн 24 дүгээр зүйл нь одоогийн хүчин төгөлдөр хуулиас ялгаатай нь реэкспортлох зохицуулалтыг нэмж, НҮБ-ын гурван конвенцийн холбогдох заалтуудыг шууд заасан (24.3), мөн импортолноос хойш мэдээлэх хугацааг одоогийн А/408 журмын 7 хоногоос 3 хоног болгон богиносгосон (24.4) байна.

Практикт хэрэгжих боломжийн хувьд, импорт, экспортын мэдүүлэг олгох тогтолцоо нь Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүрээнд аль хэдийн бүрдсэн, хуулийн төслийн тус зохицуулалтыг практикт хэрэгжих боломжтой гэж үзэж байна. Гэвч мэдээлэх хугацааг 7 хоногоос 3 хоног болгон богиносгосон нь зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад нэмэлт ачаалал үүсгэх, ялангуяа зайн алслагдсан газар байрлах гааль, хилийн боомтын нөхцөлд хүндрэл учруулах магадлалтай. Одоогийн практикт 7 хоногийн хугацаа ч зарим тохиолдолд хангалтгүй байдгийг анхаарах шаардлагатай.

Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.5-д гадаад улсын үйлдвэрлэгчийн Монгол Улс дахь гэрээт борлуулагч нь реэкспорт хийж болохоор заасан нь шинэ зохицуулалт бөгөөд энэ нь чанар, стандартын шаардлага хангаагүй бодисыг буцаан гаргах бодит хэрэгцээнд нийцсэн, практик хэрэгжих боломжтой зохицуулалт юм. Реэкспортын зөвшөөрлийн горим нь одоогийн Гаалийн тухай хуулийн тогтолцоотой нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай.¹⁴

¹³Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. Эмийн үйлдвэрлэлд тавих шаардлага.

¹⁴Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.2. Мансууруулах бодисыг хилээр нэвтрүүлэх хяналтын тусгай журам.



Хуулийн төслийн 25 дугаар зүйлд зааснаар мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг зөвхөн Засгийн газрын баталсан хилийн боомтоор нэвтрүүлэхийг шаардаж (25.8), хилийн боомтын гаалийн лабораторийн шинжилгээнд заавал хамруулахаар тусгасан (25.4), мөн гаалийн байгууллагын мэдэгдлийн хугацааг 24 цаг гэж тогтоосон (25.6) зэрэг чухал шинэчлэлтүүдийг агуулжээ.

Тус зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хэд хэдэн асуудал үүсэж болохоор байна. Тухайлбал, хилийн боомт бүрд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис шинжлэх чадавхтай лаборатори бүрдүүлэх нь Монгол Улсын газар зүйн онцлог, хүний нөөц, төсвийн хувьд хүндрэлтэй байж болох юм.

Хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.5-д “шүүх шинжилгээний байгууллага мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг судлан тогтоох, тодорхойлох харьцуулан шинжлэх зорилгоор оруулж ирсэн стандарт дээжийг энэ хуулийн 25.4-т заасан шинжилгээнд хамруулахгүй” гэж заасан практик хэрэгцээнд бүрэн нийцсэн, оновчтой зохицуулалт юм. Мөн зүйлийн 25.9-д заасан зохицуулалтын хувьд тагнуул, хил хамгаалах, цагдаа, гаалийн байгууллага хамтран хяналт тавихаар заасан нь байгууллага хоорондын уялдаа холбоог хангахыг шаардах бөгөөд байгууллага хоорондын мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх, сайжруулах шаардлагатай болохыг илэрхийлж байна.

Хуулийн төслийн 26 дугаар зүйлд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын худалдааг энэ хуулийн 11.1.3-т заасан зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхийг заажээ (26.2). Гэвч энд дугаарлалтын алдаа ажиглагдаж байна: 11.1.3-т “экспортлох” зөвшөөрлийг, 11.1.4-т “худалдах буюу ханган нийлүүлэх” зөвшөөрлийг тусгасан бөгөөд 26.2-т 11.1.4-ийг эш татах нь зөв. Мөн хуулийн төслийн 11 дүгээр зүйлд 11.1.4 дугаар 2 удаа давтагдсан (“худалдах буюу ханган нийлүүлэх” болон “эмийн сангийн үйлчилгээ” гэсэн 2 өөр заалтад ижил дугаар олгогдсон) бөгөөд энэ нь засвар шаарддаг дугаарлалтын алдаа юм. Зөвшөөрөл, захиалгыг баримтжуулан 10 жил хадгалахаар тусгажээ (26.3). Мөн мал, амьтны мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн ханган нийлүүлэлт, тайлагналын зохицуулалтыг нарийвчлан тусгасан байна.

Практикт хэрэгжих боломжийн хувьд, одоогийн байдлаар Монгол Улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис импортлох-ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй хязгаарлагдмал тооны байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Зөвшөөрөл, захиалгыг 10 жил хадгалах шаардлага нь бүртгэлийн тогтолцоо, архивын нөхцөл, цахим мэдээллийн санг бэхжүүлэхийг шаарддаг тул зарим жижиг байгууллагад нэмэлт ачаалал үүсгэх боломжтой. Гэвч энэ нь олон улсын практикт нийцсэн, хяналтын үр дүнтэй тогтолцоо бий болгоход чухал ач холбогдолтой зохицуулалт юм.

Хуулийн төслийн 27 дугаар зүйлд эмийн жор олгох нарийвчилсан зохицуулалтыг тусгажээ. Тухайлбал, жорыг зөвхөн эмчлэх эрх бүхий их эмч үйлдэх (27.1), жорын маягтыг индексийн дугаартайгаар, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын тамгаар баталгаажуулах (27.5), жорыг давхар бичиж олгохыг хориглох (27.10), нэг жорд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эм хамт бичихийг хориглох (27.18) зэрэг шаардлагуудыг тусгасан.

Мал, амьтны зориулалттай эмийн жор бичилтийг малын их эмчээр гүйцэтгүүлэхээр заасан (27.19) нь Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуультай нийцсэн, хэрэгжих боломжтой зохицуулалт юм. Гэвч хөдөө, алслагдсан сумдад малын их эмч хүрэлцээтэй байгаа эсэх нь хэрэгжилтийн чанарт нөлөөлнө.



Хуулийн төслийн 28 дугаар зүйлд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эмийг эмийн сангаас олгох нарийвчилсан зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, жоргүй олгохыг хориглох (28.2), иргэний үнэмлэх шалгаж олгох (28.4, 28.5), жор бичигдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор олгох (28.7.2), хүүхэд, согтуу хүнд олгохыг хориглох (28.7.3) зэрэг заалтуудыг оруулжээ.

Хуулийн төслийн 28.5-д заасан "жорд заасан өвчтөн, эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүнд олгоно" гэсэн зохицуулалт нь өвчтөн биечлэн ирэх боломжгүй тохиолдлыг хамарсан оновчтой зохицуулалт юм. Гэвч Хуулийн төслийн 28.3-ын тайлбарт заасан "бичиг баримт" буюу иргэний үнэмлэх, гадаад паспорт, жолоодох эрхийн үнэмлэх нь хангалттай боловч хүлээн авагчийн хувийн мэдээллийг цуглуулж, хадгалахад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шаардлагатай бүрэн нийцүүлэх хэрэгтэй.

Хуулийн төслийн 29 дүгээр зүйлд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх нарийвчилсан дотоод хяналтын тогтолцоог тусгажээ. Тухайлбал, эмчийн хяналт дор өвчтөнд хэрэглэх (29.6.1), хоосон тун шил, шахмал эмийн савыг буцааж авах, бүртгэл хөтлөх (29.6.3), бүртгэлийг 5 жил хадгалах (29.6.5) зэрэг заалтуудыг оруулсан.


Энэхүү зохицуулалт нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагуудад аль хэдийн мөрдөгдөж буй Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/408 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан журмын нарийвчилсан зохицуулалтыг хуульд тусгаж буйн илрэл юм. Хуулийн төслийн 29.6.5-д бүртгэлийг 5 жил хадгалахаар заасан бол одоогийн А/408 журмын 4.7-д 1 жил хадгалахаар заасан байгаа нь хадгалах хугацааг 5 дахин нэмэгдүүлсэн; мөн хуулийн төслийн 29.5-д тайланг улирал бүр гаргахаар заасан бол одоогийн А/408 журмын 6.3-т хагас жилээр гаргахаар заасан нь тайлагналын давтамжийг 2 дахин нэмэгдүүлсэн.¹⁵

Хуулийн төслийн 30 дугаар зүйлд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний зориулалтаар, цагдаагийн байгууллагын хяналт дор түүхээр заасан (30.1, 30.4). Энэ нь Байгалийн ургамлын тухай хууль¹⁶-ийн зохицуулалттай уялдсан, практикт хэрэгжих боломжтой зохицуулалт юм.

Хуулийн төслийн 31–38 дугаар зүйлүүдэд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах ажиллагаанд (32), зэвсэгт хүчинд (33), сургалтын зориулалтаар (34), шинжилгээний зориулалтаар (35), эрдэм шинжилгээ, судалгааны зориулалтаар (36), улсын нөөцөд (37), мал, амьтны эмд (38) ашиглах зохицуулалтыг тусгажээ. Мөн хуулийн төслийн 35 дугаар зүйлд шинжилгээний зориулалтаар ашиглахад нэр зааж жагсаасан 4 лаборатори (шүүх шинжилгээний байгууллагын лаборатори, цагдаагийн төв байгууллагын лаборатори, гаалийн хилийн боомт дахь лаборатори, эмийн үндэсний лавлагаа лаборатори)-ыг тодорхой байдлаар тусгасан байна.

¹⁵Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/408 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7-д "бүртгэлийг 1 жил хадгалж" гэсэн бол хуулийн төслийн 29.6.5-д "5 жил хадгалж" гэж нэмэгдүүлсэн; мөн А/408 журмын 6.3-т тайланг "хагас жилээр" гаргахаар заасан бол хуулийн төслийн 29.5-д "улирал бүр" гаргахаар өөрчилсөн.

¹⁶Байгалийн ургамлын тухай хуулийн 10, 13 дугаар зүйл. Ургамал хамгаалал, ашиглалтын зохицуулалт.



Хуулийн төслийн 37 дугаар зүйлд улсын нөөцийн байгууллага мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг нөөцөд бүрдүүлэхээр заасан нь гамшгийн үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад чухал зохицуулалт юм.

Хуулийн төслийн 39 дүгээр зүйлд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хадгалах нарийвчилсан шаардлагуудыг тусгажээ. Тухайлбал, техникийн хувьд бэхжүүлсэн тусгай өрөө буюу цоожтой шүүгээнд хадгалах (39.2.1), дохиолол, дуу-дүрсний бичлэгийн системээр тоноглох (39.2.2), сар бүр тооллого хийх (39.2.7), бүртгэлийг 5 жилээс доошгүй хугацааны турш хадгалах (39.2.8) зэрэг шаардлагуудыг тусгасан. Хуулийн төслийн 39.5-д гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх явцад хураагдсан бодисыг 39.2-т заасан журмаар хадгалахаар заасан нь хууль сахиулах байгууллагад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хадгалалтын суурь бүтэц, нөхцөлийг бүрдүүлэхийг шаардаж байна.

Хуулийн төслийн 40 дүгээр зүйлд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг зөвхөн зөвшөөрлийн үндсэн дээр тээвэрлэхийг заасан (40.1). Зориулалтын автотээврийн хэрэгсэл дохиолол, дуу-дүрсний бичлэгийн систем, байршил тогтоогч, хэм, чийг хэмжигчтэй байх (40.5) шаардлагыг тусгасан. Мөн шуудан, илгээмжээр илгээх, зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг хориглосон (40.6) байна.


Монгол Улсын хөдөө, орон нутгийн замын нөхцөл, зайн алслагдмал байдлыг харгалзахад энэ шаардлагыг бүрэн хангах нь зарим тохиолдолд хүндрэлтэй байж болно. Харин төслийн 40 дүгээр зүйлийн 40.3-т яаралтай тусламж, үйлчилгээнд хэрэглэх эмийг тээвэрлэхэд зөвшөөрлийн шаардлага хамаарахгүй гэж заасан нь бодит хэрэгцээнд нийцсэн, амь насыг аврах үйл ажиллагааг хүндрүүлэхгүй, оновчтой зохицуулалт байна.

Түүнчлэн, тус хуулийн төслийн 41 дүгээр зүйлд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг устгах нарийвчилсан журмыг тусгажээ. Энэ зүйлд цагдаагийн байгууллага шүүхийн шийдвэрийг үндэслэн устгах (41.1), устгалын комисс томилж, дуу-дүрсний бичлэгээр баримтжуулах, мөн зөвшөөрөл эзэмшигч нь хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн цагдаагийн байгууллагатай хамтран устгах (41.2) зэрэг шаардлагуудыг тусгасан байна.

Практикт хэрэгжих боломжийн хувьд, устгалын зохицуулалт нь хэд хэдэн байгууллагын хамтын ажиллагааг шаарддаг(цагдаагийн байгууллага, хяналтын улсын байцаагч, зөвшөөрөл эзэмшигч). Мөн хуулийн төслийн 41 дүгээр зүйлийн 41.3.3-т устгасан талаарх акт, дуу-дүрсний бичлэг зэрэг баримт бичгийг 10 жил хадгалахаар заасан нь хууль бус эргэлтийг илрүүлэх, нотлох ач холбогдолтой боловч архивын нөхцөл, цахим хадгалалтын дэд бүтцийг шаардахаар байна.

Мөн устгалын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах тодорхой аргачлалыг хуулийн төсөлд тусгаагүй нь Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн шаардлагатай нийцүүлэх хэрэгтэйг харуулж байна.

Харин хуулийн төслийн 42 дугаар зүйлд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг устгах нарийвчилсан зохицуулалтыг тусгасан бөгөөд тус зүйлд газар тариалангийн бүс нутагт газар тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (42.3), бусад газарт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (42.4) устгах ажлыг хариуцах, тариалангийн газрын эзэмшигч, ашиглагч нь талбайн захаас гадагш 200 метр хүртэлх зайд ургасан ургамлыг өөрийн зардлаар устгах үүрэгтэй (42.11), цагдаагийн байгууллага 3 жил тутам тархацын хяналтын судалгаа хийх (42.16) зэрэг зохицуулалтуудыг оруулжээ.



Манай улсын хувьд жил бүр мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг устгах ажил хийгддэг бөгөөд энэхүү ажил нь зардал шаарддаг тул улсын төсөвт тус ажлыг гүйцэтгэхэд шаардах төсвийн хангалттай тавьж өгөх мөн хуулийн төсөлд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлын тархацыг 3 жил тутам бүрэн судалж, устгах ажлыг зохион байгуулахаар тусгасан нь тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардах техник, тоног төхөөрөмж, хүний нөөц, боловсон хүчин, санхүүгийн асуудлыг сайтар анхаарч улсын төсөвт тусгах шаардлагатай болохыг харуулж байна. Энэхүү зохицуулалтын хэрэгжилт нь нэг талаас улсын төсвөөс олгож буй санхүүжилттэй салшгүй холбоотой.

Хуулийн төслийн 42 дугаар зүйлийн 42.9-д устгалын зардлыг улсын төсөв болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан хөрөнгөөс санхүүжүүлэхээр заасан нь санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой заасан байна. Өөрөөр хэлбэл, дээрх зохицуулалтуудын хэрэгжилт нь өөр хоорондоо нягт уялдаа холбоотой бөгөөд шаардлагатай санхүүжилтийг олгох эсэх нь тухайн зохицуулалтын хэрэгжилтэд шууд нөлөөлөхөөр байна.

Мөн тус зүйлийн 42.11-д тариалангийн газрын эзэмшигч, ашиглагчид ургамал устгах үүрэг хүлээлгэсэн нь 42.13-т заасан цагдаагийн байгууллагын мэдэгдэл, шаардлагын тогтолцоотой хамт хэрэгжих боломжтой боловч тариалангийн газар эзэмшигч нар энэ үүргийг биелүүлэх мэдлэг, дадлага, мөн ургамлыг таних чадвартай эсэх нь чухал асуудал юм.

Хуулийн төслийн 23-42 дугаар зүйлийн зохицуулалтыг "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд шинжилж үзэхэд хуулийн төслийн зохицуулалт нь одоогийн хүчин төгөлдөр хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгож, засаж сайжруулан нарийвчлан тусгасан байна. Түүнчлэн, одоо практикт хэрэгжүүлэн ажиллаж буй зохицуулалтуудыг сайжруулан, нарийвчлан тусгах нь хуулийн төслийн тухайн зохицуулалтууд практикт хэрэгжих боломжтой болохыг илэрхийлж байна.

Харин хуулийн төслийн хувьд зарим зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүний нөөц, санхүүжилт, бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл шаардахаар байна. Өөрөөр хэлбэл, тус хуулийн төслийн зардлын тооцоо, нэмэлт санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсний үндсэн дээр тухайн хуулийн төсөл практикт хэрэгжих боломжтой байна.

Мөн тус хуулийн төсөлд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих асуудлыг олон талаас нь авч үзсэн болох нь харагдаж байна.

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тус шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зүйл, заалт нь найруулга, хэл зүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон болон логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгана. Ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан болон “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг нарийвчлан давхар шалгана. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хүснэгт 7. Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1	Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.16, 4.1.17 дахь заалт	Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д заасан “мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг бусдад хэрэглүүлэх” мөн зүйлийн 4.1.17-д заасан “мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг бусдад хэрэглэх” талаар ойлголтыг тодорхойлолтыг нягтлан үзэж, боловсронгуй болгох.	Субъектив шинж (хүсэл зорилгын) болон объектив шинж (үйлдлийн) ялгааг тодорхой зааглан тайлбарлах нь зүйтэй.
2	Төслийн 4 дүгээр зүйл	Нэр томъёоны тодорхойлолтын дарааллыг нягтлан үзэх.	Тодорхойлолтуудыг (а) бодисын ойлголт, (б) үйлдлийн ойлголт, (в) этгээдийн ойлголт, (г) эрх зүйн байдлын ойлголт гэж ангилж дарааллуулна.
3	Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-11.1.7 дахь заалт	Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг хоёр удаа давхардуулан дугаарласан байна.	Иймд төсөлд давхардуулан бичсэн 11.1.4 дэх заалтыг 11.1.5 дахь заалт болгон өөрчилж, “11.1.4-11.1.7 дахь заалт”-ыг “11.1.5-11.1.8 дахь заалт” болгон зөв дугаарлах.
4	Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг	Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “...дагуу байгуулагдсан үйл ажиллагаа явуулж байгаа...” гэсний “байгуулагдсан” гэх үг нь бусдаар үйлдэгдэх хэвийн нөхцөлтэй байна.	Иймд тус зохицуулалтын “...байгуулагдсан...” гэснийг “...байгуулсан...” гэж өөрчлөх.
5	Төслийн 26 дугаар зүйл	Төслийн 26 дугаар зүйлд “28.8-28.10” гэж алдаатай байдлаар дугаарласан байна.	Иймд төслийн 26 дугаар зүйлд “28.8-28.10” гэснийг “26.4-26.6” гэж өөрчлөх.
6	Төслийн 27 дугаар зүйлийн 27.17-27.20 дахь заалт	Төслийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсгийн дараа 27.11-27.16 дахь хэсгийг алгасаж, 27.17-27.20 дахь хэсгийг дугаарласан байна.	Иймд төслийн 27.17-27.20 дахь хэсгийн дугаарыг “27.11-27.14 дэх хэсэг” болгон зөв дугаарлах. Мөн тус зохицуулалтын дугаарлалтад өөрчлөлт орсноос хуулийн төслийн бусад зохицуулалтад эшлэж тусгасан байдлыг шалган үзэж засах. Тухайлбал, 27.19

			дэх хэсэгт заасан зохицуулалтад тусгасан "...27.10, 27.17, 27.18..." гэснийг өөрчлөх.
	Төслийн 27 дугаар зүйлийн 27.19 дэх заалт	Төслийн 27 дугаар зүйлийн 27.19 дэх хэсэгт "...баримтлана." гэж алдаатай бичсэн байна.	Иймд тус зохицуулалтын "...баримтлана." гэснийг "...баримтална." гэж өөрчлөх.
	Төслийн 29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсэг	Төслийн 29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсэгт "Энэ хуулийн дарга батална. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид дарга тус тус батална." гэж заажээ. Энэхүү зохицуулалтыг нэг дор ийнхүү тусгасан нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Иймд тус зохицуулалтын "...мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид дарга тус тус батална." Гэснийг тусад нь тусгах. Мөн тус зохицуулалтын найруулгыг засах нь зүйтэй. Ийнхүү өөрчилсөн тохиолдолд тус зүйлийн 29.8-29.11 дэх хэсгийн дугаарлалт, 29.9 дэх хэсгийн зохицуулалтад тусгасан "29.8" гэснийг өөрчлөх шаардлагатай болох юм.
	Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг	Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт "...30.1-т..." гэснийг өөрчлөх.	Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт "...30.1-т..." гэснийг "...30.1-д..." гэж өөрчлөх.
	Төслийн 35 дугаар зүйлийн 35.7, 35.8 дахь хэсэг	Төслийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг гэснийг дараа 35.5-35.7 дахь хэсгийг алгасаж, "35.8, 35.9" гэж дугаарласныг засах.	Төслийн 35 дугаар зүйлийн 35.7, 35.8 дахь хэсгийн дугаарлалтыг "35.5, 35.6" гэж өөрчлөх.
	Төслийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг	Нэг өгүүлбэрт 10 гаруй нөхцөл жагсаасан нь тодорхой бус байдал үүсгэж болзошгүй: <i>"хэрэглэх хугацаа дууссан, чанараа алдсан, үйлдвэрийн технологийн зааврын дагуу хийгдээгүй, чанарын баталгаажуулалтгүй, сав, баглаа боодлын битүүмжлэл, бүрэн бүтэн байдал алдагдсан, эсхүл шошго, нэр хаяггүй..."</i>	Иймд төслийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт заасан зохицуулалтыг задалж, заалт байдлаар тусгах нь зүйтэй. Тухайлбал, 41.2.1, 41.2.2... гэх.
	Төслийн 42 дугаар зүйл	42.13–42.15-ийн дотоод дараалал логик тасарсан: 42.13 мэдэгдэл, 42.14 устгах үүрэг, 42.15 нь 42.14-ийн биелэлтгүй байх тохиолдлын зохицуулалт байх ёстой байтал өөртөө лавлагаа хийснээр уг логик тасарчээ.	42.15-д "42.14-т заасан үүрэг" гэж засч, логик дараалалд нийцүүлнэ.

Төслийн 42 дугаар зүйлийн 42.15 дахь хэсэг	Төслийн 42 дугаар зүйлийн 42.15 дахь хэсэгт "...энэ хуулийн 42.15-д..." гэж буруу зохицуулалт эшлэснийг засах.	Төслийн 42 дугаар зүйлийн 42.15 дахь хэсэгт "...энэ хуулийн 42.15-д..." гэж буруу зохицуулалт эшлэснийг засаж, зөв зохицуулалтыг тусгах.
Төслийн 47 дугаар зүйл	Төслийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт "...47.1.6..." гэсний дараа "...47.4.7..." гэж алдаатай дугаарласныг засах.	Иймд тус зүйлд "47.4.7" гэж заасныг "47.1.7" гэж өөрчлөх.
Төслийн 56 дугаар зүйл	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүрэг (56 дугаар зүйл)-ийн бүх дэд заалт төсөлд буруу дугаарлагдсан: "56.1. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих... байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:" "51.1.1. мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хорих байгууллагад хуульбусаар нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх..." "51.1.2. мансууруулах, нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн талаар цагдаагийн байгууллагатай мэдээлэл солилцох..."	Иймд тус зүйлд "51.1.1-51.1.7" гэснийг "56.1.1-56.1.7" гэж өөрчлөх.
Төслийн 58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсэг	Төслийн 58 дугаар зүйлийн 58.3. дахь хэсэгт <i>"Сайн дурын шинжилгээгээр мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн нь тогтоогдсон хүнийг энэ хуулийн 52.2.2, 52.2.3-т заасан тусламж, үйлчилгээнд сайн дурын үндсэн дээр хамруулна"</i> гэж тусгасан боловч тус хуулийн төсөлд 52 дугаар зүйлийн 52.2.2, 52.2.3 дахь заалт тусгагдаагүй байна	Иймд төслийн 58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсэгт заасан зохицуулалтыг нягтлан үзэж, өөрчлөх.

Тус хуулийн төслийн зарим зүйл, заалт нь бодлогын баримт бичгийн зүйл, заалт шиг хэт ерөнхий байдлаар тусгагдсан байна.

Хүснэгт 8. Хуулийн төслийн Бүлгийн дарааллын логик шинжилгээ

Бүлэг	Гарчиг	Тайлбар
1 (зүйл 1–5)	Нийтлэг үндэслэл	Зорилт, хамрах хүрээ, нэр томьёо — логик дараалал зөв
2 (зүйл 6–10)	Ангилал, жагсаалт, эргэлт	"Эргэлт" нь ангилал, жагсаалтаас ялгаатай агуулга. 2 дугаар бүлгийн гарчигт тусгах нь зохистой
3 (зүйл 11–22)	Зөвшөөрөл	Дотоод уялдаа хангалттай — зарчимд нийцнэ
4 (зүйл 23–42)	Холбоотой үйл ажиллагаа	20 зүйл — хамгийн том бүлэг. 39-р зүйлийн хадгалалтын техникийн шаардлага нь стандартад тусгагдах ёстой агуулга

5 (зүйл 43–57)	Байгууллагын тогтолцоо	56-р зүйлийн буруу дугаарлалт (51.1.х) нь энэ бүлгийн бүтцийг ноцтойгоор задалсан
6 (зүйл 58–65)	Тусламж, үйлчилгээ	7-р бүлгийн (Мэдээллийн сан) өмнө орсон нь логик тасралт — мэдээллийн сан нь хяналтын дэд бүтэц учраас 5-р бүлгийн дараа байрлах нь логик
7 (зүйл 66–70)	Мэдээллийн сан	Хяналтын механизмын нэг хэсэг тул 5-р бүлгийн дараагаар байрлах нь логик. Санал: 5→7→6 дарааллаар өөрчлөх
8 (зүйл 71)	Урьдчилан сэргийлэх	Хуулийн 3 зорилтын нэг болох "урьдчилан сэргийлэх" нь ганц зүйлтэй (71) нэг бүлэгт тусгагдсан нь зорилт ба агуулгын жин ноцтой тэнцвэргүй
9 (зүйл 72–75)	"Бусад зүйл"	72-р зүйлд гадаад иргэний оршин суух зөвшөөрлийг цуцлах зохицуулалт орсон нь 5-р бүлгийн байгууллагын чиг үүрэгт тусгах ёстой агуулга. "Бусад" бүлэгт үндсэн зохицуулалт байрлах нь зарчимтай зөрчилдөнө

Түүнчлэн, энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан.

Хүснэгт 9. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн бүтэц, хэлбэр	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна: 28.1.1.хуулийн төслийн гарчиг; 28.1.2.хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл; 28.1.3.зүйлийн доторх хэсэг; 28.1.4.хэсгийн доторх заалт; 28.1.5.заалтын доторх дэд заалт; 28.1.6.шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, анги.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй.

29.1.4. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.5 Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Харилцан уялдаа хэсэгт төслийн зарим зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилтэй байгааг судлан үзсэн болно.
29.1.6. Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.8. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага.	
30.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.2. Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.3. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Өмнөх хүснэгтэд төслийн зарим зүйл, заалт нуршуу, тодорхойгүй, найруулга зүйн алдаатай байдлыг судлан үзсэн.
30.1.4. Хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Төслийн 43 дугаар зүйлийн 43.1.6-д "...бүрэн хянах.." гэсний "бүрэн" гэх үг нь хүч оруулсан утгатай байна. Төслийн 71 дүгээр зүйлийн 71.2.1-д "...бүх үйл ажиллагааг..." гэсний "бүх" гэх үг нь хүч оруулсан утгатай байна.
30.1.5. Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тухайн хууль тогтоомжийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуй, байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалт байх тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 6 дугаар зүйл, 58 дугаар зүйл, 59-65 дугаар зүйл, 66-70 дугаар зүйл, 71-д дүн шинжилгээ хийнэ.

Хуулийн төслийн 6 дугаар зүйл буюу мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын ангиллын зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ


Хуулийн төслийн 6 дугаар зүйлд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, түүний угтвар бодисын ангиллыг тодорхойлсон нь өмнөх хуульд байгаагүй шинээр тусгасан зохицуулалт байна. Тус төслөөр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний угтвар бодисын ангиллыг дараах байдлаар авч үзжээ.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хүний эрүүл мэндэд үзүүлэх хор уршиг, урвуулан хэрэглэх эрсдэл, урвуулан хэрэглэсний улмаас бие болон сэтгэцийн хамаарал үүсгэх сөрөг нөлөө болон хүн ам, мал, амьтны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх хэрэгцээ, шаардлагыг харгалзан дараах байдлаар ангилсан.

Хүснэгт 10. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал

“А” ангилал	“А” ангиллын бодисын жагсаалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтэд оруулахыг хориглосон бодисын жагсаалт байх ба тус ангилалд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэрэглэдэггүй мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хамааруулна.
“Б” ангилал	“Б” ангиллын бодисын жагсаалт нь хүн ам, мал, амьтны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хяналттайгаар хэрэглэдэг мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт байна.
“В” ангилал	“В” ангиллын бодисын жагсаалт нь энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан ангилалд хамаарах бодис агуулаагүй боловч тухайн бодисыг урвуулан хэрэглэснээр мансууруулах, сэтгэцэд нөлөө үзүүлэх эрсдэлтэй эм, бодисын жагсаалт байна.
“Г” ангилал	“Г” ангиллын бодисын жагсаалт нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлын жагсаалт байна.

НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 9 дүгээр зүйлд “Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 9 дүгээр зүйлд “Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй. Баривчлагдсан шалтгааныг хүн бүрд баривчлах үед нь мэдэгдэхийн зэрэгцээ буруутгаж байгаа аливаа үндэслэлийг даруй мэдэгдэнэ. Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй. Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно. Баривчлагдаж эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүнийг хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй. Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон



этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.” гэж тус эрхийг баталгаажуулсан байдаг.

Үндсэн хуулиар хамгаалсан туйлын эрхээс бусад үндсэн эрхийг хязгаарлахад наад зах нь дараах зургаан гол нөхцөлийг Монгол Улсын Үндсэн хууль тавьдаг: (1) хүний эрхэд тавьж буй аливаа хязгаарлалтыг хуульд тодорхой заах; (2) хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой байх; (3) хязгаарлалт нь эдгээр зорилгын нэгэнд хүрэхэд зайлшгүй, тохирсон байх (proportionality); (4) үндсэн эрхийг аль болох эдлүүлэх; (5) ялгаварлан гадуурхахгүй байх; (6) хараат бус шүүхээр хянагддаг байх. Иймд, үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалт нь эдгээр зургаан нөхцөлийг аль нэгийг хангаагүй бол уул эрхийн зөрчил болно.¹⁷

Мөн түүнчлэн НҮБ-ын 1961 оны конвенцийн 3 дугаар зүйлд ангилалд оруулах саналыг ДЭМБ-ын мэргэжлийн зөвлөл (WHO Expert Committee on Drug Dependence) гаргаж, НҮБ-ын Мансууруулах бодисын комисс (Commission on Narcotic Drugs) батлах журам тогтоосон. Герман Улсын Betäubungsmittelgesetz (BtMG)-ийн 1 дүгээр зүйлд бодисын жагсаалтыг хуулийн хавсралтаар (Anlage I–III) шууд тогтоож, Засгийн газрын тогтоолоор (Rechtsverordnung) нэмэлт оруулах боломж олгосон ч мэргэжлийн зөвлөх хороо (Sachverständigenausschuss) заавал саналаа өгөх журамтай.¹⁸ Иймд олон улсын жишгээр ангиллын шийдвэр гаргах үйл явцад мэргэжлийн бие даасан байгууллагын оролцоо зайлшгүй.

Дөрвөн шатлалт ангилал нь НҮБ-ын дээрх конвенцуудын жагсаалтын бүтэцтэй зарчмын хувьд нийцэж байгаа нь олон улсын хүрээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц.¹⁹ Хуулийн төслийн 6.1 дэх хэсгийн "тайлбар" хэсэгт ангилал бүрийн утга агуулгыг товч тодорхойлсон нь хуулийг хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой. Хуулийн төслийн 6.3-т шинэ бодисыг "нэн даруй" ангилалд оруулах зохицуулалт нь синтетик каннабиноид, фентанилын аналог зэрэг хурдацтай өөрчлөгдөж буй хууль бус зах зээлийн бодит нөхцөл байдалд уян хатан хариу арга хэмжээ авах боломж олгоно.

Хуулийн төслийн холбогдох зохицуулалтуудын хувьд дараах асуудлууд гарч болзошгүй. Нэгд, хуулийн төслийн 6.4-т жагсаалтыг "жил бүр шинэчлэн батална" гэж заасан нь Засгийн газрын хуралдаанаар жил бүр дөрвөн ангиллын жагсаалтыг дахин батлах гэсэн утгатай. Монгол Улсын Засгийн газрын ажиллах горимыг харгалзвал энэ нь (а) захиргааны хэт их ачаалал, (б) жил бүр шинэчлэгддэг жагсаалтын тогтворгүй байдлаас үүдэн аж ахуйн нэгжүүд (эмийн сан, ханган нийлүүлэгч) урьдчилан төлөвлөх, үйл ажиллагаагаа тохируулах боломж хомсдох, (в) 6.3-тай утга зүйн давхцал үүсгэх зэрэг сөрөг нөлөөтэй. Тухайлбал, В ангилалд байсан бодисыг Б ангилалд шилжүүлсэн тохиолдолд тус бодисыг хэрэглэж байсан бүх байгууллага шинэ зөвшөөрлийн нөхцөл хангах ёстой болох бөгөөд эдгээрийг хуулиар нарийвчлан зохицуулаагүй нь хүндрэл учруулна.

¹⁷О.Мөнхсайхан, “Монгол улсын үндсэн хууль: туйлын эрхээс бусад үндсэн эрхийн хязгаарлалтад тавих гол нөхцөл” эрдэм шинжилгээний өгүүлэл, (2021), 1 дэх тал.

¹⁸Герман Улсын Betäubungsmittelgesetz (BtMG, Мансууруулах бодисын хууль)-ийн 1 дугаар зүйл: бодисын ангиллыг хуулийн хавсралтаар (Anlage I–III) шууд тогтоодог бөгөөд Засгийн газрын тогтоолоор (Rechtsverordnung) нэмэлт оруулах боломжтой; гэхдээ мэргэжлийн зөвлөх хороо (Sachverständigenausschuss) заавал саналаа өгдөг.

¹⁹Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенц (Convention on Psychotropic Substances, 1971), 2 дугаар зүйл: хяналтын хамрах хүрээ, ангилал.

Хоёрт, А ангиллын бодисыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэрэглэхийг бүрэн хориглосон (8.2) нь зарим тохиолдолд хүний эрхийн асуудал үүсгэнэ. Тухайлбал, терминал шатны хорт хавдартай өвчтөнд хөнгөвчлөх эмчилгээнд (palliative care) шаардлагатай тодорхой бодисууд А ангилалд орж болзошгүй бөгөөд энэ нь тухайн өвчтөний өвдөлтгүй байх эрхийг (Монгол Улсын Үндсэн хуулийн 16.1 — амьд явах эрх, 16.2 — аюулгүй орчинд амьдрах эрх) зөрчиж болно.

Мөн ангиллыг зохицуулсан нь тухайн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой зохицуулалт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нөлөөтэй байхаас гадна Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зохицуулалтын хувьд ач холбогдолтой. Тус хуулийн төслийн дагалдан гарах хуулийн төсөлд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл багтсан ба холбогдох гэмт хэргийн зохицуулалтад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангиллыг тусгажээ.

Хүснэгт 11. ЭХНӨОтХ-ийн төсөл дэх холбогдох гэмт хэргийн зохицуулалтад тусгасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал

Эрүүгийн хуульд нэмж буй гэмт хэрэг	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангиллын талаар зохицуулалт
20.20 дугаар зүйл. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар хэрэглэж мансуурах	1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэж мансуурсан зөрчилд хоёр удаа шийтгэгдсэн хүн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг дахин хэрэглэж мансуурсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
20.21 дүгээр зүйл.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авахаар захиалах, олж авах, худалдан авах, дамжуулах, зуучлах	1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, худалдах, түгээх, экспортлох, импортлох зорилгоор захиалсан, эсхүл олж авсан, эсхүл худалдан авсан, эсхүл дамжуулсан, эсхүл зуучилсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ зүйлд заасан гэмт хэргийг: 2.1.байнга тогтвортой; 2.2.бүлэглэж; 2.3.арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй, эсхүл өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй хүнийг оролцуулж; 2.4.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон бодисыг 10 хүртэл грамм, эсхүл “Б” жагсаалтад орсон бодисыг 200 граммаас 1 хүртэл килограмм хэмжээгээр үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ зүйлд заасан гэмт хэргийг: 3.1.зохион байгуулалттай гэмт бүлэг; 3.2.албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж; 3.3.бага насны хүүхэд оролцуулж; 3.4.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон бодисыг 10 грамм ба түүнээс дээш хэмжээтэй, эсхүл “Б” жагсаалтад орсон бодисыг 1 килограмм ба түүнээс дээш хэмжээгээр үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
20.22 дугаар зүйл.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт	2.5. Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон бодисыг 10 хүртэл грамм, эсхүл “Б” жагсаалтад орсон бодисыг 200 граммаас 1 хүртэл килограмм хэмжээгээр үйлдсэн;

бодисыг хууль бусаар бусдад өгөх, бусдад хэрэглэх, бусдад хэрэглүүлэх	2.6.өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй хүнийг оролцуулж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ зүйлд заасан гэмт хэргийг: 3.1.зохион байгуулалттай гэмт бүлэг; 3.2.албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж; 3.3.бага насны хүүхэд оролцуулж, уруу татаж, өдөөн турхирч, хууран мэхэлж; 3.4.хорих ял эдлүүлэх газар, эсхүл сурагч, оюутны сургалтын үйл ажиллагаа явуулдаг газарт үйлдсэн; 3.5. Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон бодисыг 10 грамм ба түүнээс дээш хэмжээтэй, эсхүл “Б” жагсаалтад орсон бодисыг 1 килограмм ба түүнээс дээш хэмжээгээр үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
20.28 дугаар зүйл.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бэлтгэх, тээвэрлэх, илгээх, хадгалах	2.5. Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон бодисыг 10 хүртэл грамм, эсхүл “Б” жагсаалтад орсон бодисыг үйлдсэн; 3.5. Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон бодисыг 10 грамм ба түүнээс дээш хэмжээтэй, эсхүл “Б” жагсаалтад орсон бодисыг 1 килограмм ба түүнээс дээш хэмжээгээр үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
20.29 дүгээр зүйл.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдах	2. Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон хориглосон бодис, эсхүл шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.4. Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон бодисыг 5 граммаас 10 хүртэл грамм, эсхүл шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг 5 граммаас 10 хүртэл грамм, эсхүл “Б” жагсаалтад орсон бодисыг 200 граммаас 1 килограмм хүртэл хэмжээгээр үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 4.5 Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон бодисыг 10 грамм ба түүнээс дээш хэмжээтэй, эсхүл шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг 10 грамм ба түүнээс дээш хэмжээтэй, эсхүл “Б” жагсаалтад орсон бодисыг 1 килограмм ба түүнээс дээш хэмжээгээр үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
20.30 дугаар зүйл.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх	2. Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон хориглосон бодис, эсхүл шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.4. Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон бодисыг 5 граммаас 10 хүртэл грамм, эсхүл шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг 5 граммаас 10 хүртэл грамм, эсхүл “Б” жагсаалтад орсон бодисыг 200 граммаас 1 килограмм хүртэл хэмжээгээр үйлдсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

	4.4. Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон бодисыг 10 грамм ба түүнээс дээш хэмжээтэй, эсхүл шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг 10 грамм ба түүнээс дээш хэмжээтэй, эсхүл “Б” жагсаалтад орсон бодисыг 1 килограмм ба түүнээс дээш хэмжээгээр үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
20.31 дүгээр зүйл.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар үйлдвэрлэх	1. Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтаас бусад жагсаалтад орсон мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хуульд заасан зөвшөөрөлгүй этгээд үйлдвэрлэсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон хориглосон бодис, эсхүл шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар үйлдвэрлэсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.4.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон бодисыг 5 граммаас 10 хүртэл грамм, эсхүл шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг 5 граммаас 10 хүртэл грамм, эсхүл “Б” жагсаалтад орсон бодисыг 200 граммаас 1 килограмм хүртэл хэмжээгээр үйлдсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 4.4. Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон бодисыг 10 грамм ба түүнээс дээш хэмжээтэй, эсхүл шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг 10 грамм ба түүнээс дээш хэмжээтэй, эсхүл “Б” жагсаалтад орсон бодисыг 1 килограмм ба түүнээс дээш хэмжээгээр үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хуулийн төслийн 58 дугаар зүйл буюу мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээг эрт илрүүлэх зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 58 дугаар зүйл буюу мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээг эрт илрүүлэх зохицуулалтыг дараах байдлаар зохицуулсан.

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээг сайн дурын шинжилгээгээр эрт илрүүлж болох бөгөөд сайн дурын шинжилгээ-оношилгоог мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага болон магадлан итгэмжлэгдсэн лаборатори, шүүх шинжилгээний байгууллага хийнэ.
- Сайн дурын шинжилгээг тухайн хүний хүсэлтээр, эсхүл эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр хийнэ.
- Сайн дурын шинжилгээгээр мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн нь тогтоогдсон хүнийг энэ хуулийн 52.2.2, 52.2.3-т заасан тусламж, үйлчилгээнд сайн дурын үндсэн дээр хамруулна.
- Сайн дурын шинжилгээгээр мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн нь тогтоогдсон хүний эрх зүйн байдлыг дордуулах, хүний эрх, эрх чөлөөтэй нь холбоотой сөрөг үр дагавар үүсгэхгүй.


- 
- Сайн дурын үндсэн дээр шинжилгээ, тусламж, үйлчилгээнд хамрагдсан хүнийг мөрдөн мөшгөх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахаар өгсөн мэдээллийг түүний эсрэг ашиглах, мөрдөн шалгах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахыг хориглоно.

Оодоогийн эрх зүйн зохицуулалт буюу 2002 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх, шинжилгээ хийх зохицуулалтыг тусгаагүй бөгөөд журмаар зохицуулж байсан. Тодруулбал, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/227 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Химийн шинжилгээ хийх журам”-ын 3 дугаар зүйлд дараах байдлаар тусгасан.

- Спиртийн агууламж тодорхойлох шинжилгээ хийх биологийн дээж (цус, шээс, ходоодны шингэн) 4 мл-ээс дээш хэмжээтэй;
- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис тодорхойлох шинжилгээ хийхэд цус 10 мл-ээс дээш хэмжээтэй, шээс 40 мл-ээс дээш хэмжээтэй;
- Үсний дээжийг толгойны ар тал буюу дагзны хэсгээс шаардлага хангахуйцаар 2 хэсэг газраас (А, В сорьц) авсан;
- Үсний дээжийг шинжилгээнд авахаас өмнө дагалдах хуудсыг асуулт тус бүрээр гаргацтай бичиж ирүүлсэн;
- Хумсны дээж авахдаа баруун гарын бүх хурууны хумсыг 1 уутанд, зүүн гарын бүх хурууны хумсыг 1 уутанд тус бүр хийж, гаргацтай хаяглан ирүүлсэн;
- Шинжилгээ хийхэд зориулж авсан дээжийг хаяглахдаа он, сар, өдөр, цаг, минутыг гаргацтай бичсэн;
- Шинжилгээний дээжийг 1 удаагийн лац ашиглан битүүмжлэн ирүүлсэн.

Ийнхүү журмаар зохицуулсан байсныг хуульд тусгаж зохицуулж байгаа нь Үндсэн хуулийн 16.13 дугаар зүйлд заасан хүний халдашгүй байх эрхийг бэхжүүлэх ач холбогдолтой байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж тусгасан ба Монгол Улсын иргэн дээрх эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэхээр хуульчилсан. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж төрөөс тус эрхийг баталгаажуулах талаар тусгасан.



Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх нь Үндсэн хуулиар баталгаажуулсан хэн боловч дур мэдэн халдаж болохгүй туйлын эрх²⁰. Нэгэнт хүн бүр эрх зүйн этгээд байхын дээр Монгол Улсын төртэй харилцан эрх эдэлж, үүрэг хүлээх байдлаар эрх зүйн харилцаанд оролцох ёстой болсон учраас Үндсэн хуульд тусгагдсан эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх ёстой²¹.

Олон улсын хэмжээнд мансууруулах бодисын хэрэглээг эрүүгийн хэргийн хүрээнд авч үзэхээс эрүүл мэндийн асуудал болгон авч үзэх (decriminalisation of personal use) чиг хандлага тогтсон бөгөөд НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газар (UNODC)-ын 2024 оны Дэлхийн мансууруулах бодисын тайланд энэхүү арга барилыг олон улсад өргөнөөр хүлээн зөвшөөрч буйг тэмдэглэсэн.²² Жишээ нь Португал Улс 2000 оноос хойш бага хэмжээний бодис эзэмших, хэрэглэхийг эрүүгийн гэмт хэргээс хасаж, захиргааны зөрчил болгон шинэчилсэн бөгөөд үүний зэрэгцээ "Урьдчилан сэргийлэх комисс" (Comissão para a Dissuasão da Toxicodependência) байгуулж, хэрэглэгчдийг эрүүгийн шийтгэлийн оронд тусламж, үйлчилгээнд чиглүүлдэг байна.²³

Төслийн 58.4-т тодорхойлсон "эрх зүйн байдлыг дордуулахгүй" зохицуулалт нь мансууруулах бодис хэрэглэгчдийн хувьд шинжилгээнд хамрагдах хүсэл зоригийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж болно. ДЭМБ-ын International Standards for the Treatment of Drug Use Disorders (2020)-д "хамааралтай хүнд тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ сайн дурын зарчим, нууцлал, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг баримтлах" ёстой гэж заасантай нийцсэн зохицуулалт юм.²⁴

Мөн төслийн 58.5-д сайн дурын тусламж, үйлчилгээний хүрээнд өгсөн мэдээллийг мөрдөн шалгах, зөрчил шалгахад ашиглахыг тодорхой хориглосон нь "хятад хана" (Chinese wall / information barrier) зарчмыг хуулийн түвшинд бий болгож, хэрэглэгчид тусламж авахад итгэлтэй хандах нөхцөлийг бүрдүүлнэ. Энэ нь Португалын "Урьдчилан сэргийлэх комисс"-ын загвартай зарчмын хувьд адил юм.

Хуулийн төслийн холбогдох зохицуулалтуудын хувьд дараах асуудлууд гарч болозшгүй.

Нэгд, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 12 дугаар зүйлд хүүхдийн саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхийг, 3 дугаар зүйлд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалахаар заасан.²⁵ Хуулийн төслийн 58.2-т "эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр" шинжилгээ хийнэ гэж заасан нь 16-17 насны өсвөр насныхны хувьд тухайн хүүхдийн зөвшөөрлийг авалгүйгээр шинжилгээ хийх боломж олгож байна. Энэ эцэг, эх нь хүүхдээ хайхардаггүй гэр бүлийн орчин нөхцөлд өсвөр насны хүүхэд өөрийн хүсэлтээр тусламж, үйлчилгээ авах эрхийг хөндөж болзошгүй юм.

Хоёрт, Хуулийн төслийн 58.4, 58.5 дахь хэсгүүд нь зөвхөн мөрдөн шалгах, зөрчил шалгахад ашиглахыг хориглосон. Гэвч ажил олгогч, даатгалын компани, боловсролын байгууллага, сум дүүргийн хэсгийн төлөөлөгч зэрэг гуравдагч этгээд тус мэдээллийг шаардах, ашиглах боломжийг хуулиар тодорхой хааж өгөөгүй. Жишээлбэл, ажил олгогч

²⁰ Г.Совд, Монгол улсын Үндсэн хууль, хүний эрх /Харьцуулсан эрх зүй/, (УБ, 1999), 51 дэх тал.

²¹ Г.Эрдэнэбат, Хүний халдашгүй эрх, (УБ, 2002), 9 дэх тал.

²² UNODC, World Drug Report 2024.

²³ Португал Улсын Lei 30/2000 (Decriminalisation law): бага хэмжээний мансууруулах бодис эзэмших, хэрэглэхийг эрүүгийн гэмт хэргээс хасаж, захиргааны зөрчил болгосон; "Dissuasion Commission" (урьдчилан сэргийлэх комисс) байгуулсан туршлага.

²⁴ ДЭМБ (WHO), International Standards for the Treatment of Drug Use Disorders, 2020.

²⁵ НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (Convention on the Rights of the Child, 1989), 12 дугаар зүйл.



нь ажилд орох хүсэлтэй иргэнээс мансууруулах бодисын шинжилгээний түүх шаардах, даатгалын компани нь мэдээллийг даатгалын нөхцөлд ашиглах зэрэг тохиолдлууд бий болж болзошгүй бөгөөд энэ нь 58.4-т заасан "эрх зүйн байдлыг дордуулахгүй" зарчмыг бодитоор хэрэгжүүлэхэд саад учруулна.

Гуравт, Хуулийн төслийн 58.1-д магадлан итгэмжлэгдсэн байгууллагаар шинжилгээ хийлгэхээр заасан нь мэргэжлийн чанарыг хангах зорилготой зохицуулалт. Гэвч Монгол Улсын нийгмийн бодит нөхцөл байдлыг харгалзвал хөдөө орон нутагт (ялангуяа алслагдсан сум, суурин газруудад) магадлан итгэмжлэгдсэн лаборатори, мэргэжлийн байгууллага хязгаарлагдмал байх тул үүнийг харгалзах шаардлагатай.

Хуулийн төслийн 59-65 дугаар зүйл буюу мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай тусламж, үйлчилгээний зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 59-65 дүгээр зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээний зохицуулалтыг дараах байдлаар зохицуулсан.

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнд тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Эмийн болон сэтгэл заслын эмчилгээ ;
- Донтох эмгэгийг нөхөн сэргээх эмчилгээ;
- Донтох эмгэгийг нөхөн сэргээх төв;
- Албадан эмчилгээ;
- Нийгмийн хамгааллын арга хэмжээ;
- Зан үйлд нөлөөлөх сургалт;

Төслийн 59.6-д эмийн болон сэтгэл заслын эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр заасан нь зарчмын хувьд зөв боловч дараах асуудлуудыг авч үзэх шаардлагатай:

Монгол Улсын эрүүл мэндийн даатгалын сан өнөөдөр зардлын нөхөн олговрын хэмжээ хязгаарлагдмал, олон төрлийн тусламж, үйлчилгээг бүрэн хамруулж чаддаггүй нь практикаас харагддаг. Даатгалд хамрагдаагүй хүмүүст (тогтмол ажилгүй, гэр оронгүй, нийгмийн эмзэг бүлэг) яаж тусламж хүрэх нь тодорхойгүй. Энэ нь мансууруулах бодисын хамаарлын хамгийн өндөр эрсдэлтэй бүлгүүд юм.

Хуулийн төслийн 59.7-д донтох эмгэгийн нөхөн сэргээх эмчилгээний зардлыг "Үндэсний хороо болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн багцад тусган санхүүжүүлнэ" гэж хуваасан. Гэвч (i) Үндэсний хороо ба орон нутаг хоорондын санхүүжилтийн хуваарилалтын хувь, (ii) аймгуудын нутаг дэвсгэр, хүн амын бүтцийн ялгааг хэрхэн тооцох, (iii) жилийн төсвийн хуваарилалтыг хэн, хэрхэн тодорхойлох зэрэг асуудлууд нээлттэй. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын олон аймаг санхүүгийн хүндрэлтэй, төсвийн дутагдалтай байгааг харгалзвал шинэ тусламж, үйлчилгээний санхүүжилтийг орон нутгийн төсвөөс гаргах нь бэрхшээлтэй.



Төслийн 62 дугаар зүйлээр Үндэсний хорооны дэргэд Донтох эмгэгийг нөхөн сэргээх үндэсний төвийг, мөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэд орон нутгийн төвүүдийг байгуулахаар заасан.

Донтох эмгэгийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ нь Монгол Улсад өнөөдөр системтэй зохион байгуулагдаагүй, хэрэглэгчдэд хүрч чадахгүй байгаа тул тусгай бүтэц байгуулах нь зарчмын хувьд зөв алхам юм. Төслийн 62.3-д Үндэсний төвийн 14 чиг үүргийг жагсаасан нь тусламж, үйлчилгээний цогц байдлыг хангахыг зорьсон нь эерэг юм.

Гэвч олон улсын туршлагаас харахад ийм цогц чиг үүргийг нэг байгууллагад төвлөрүүлэх нь үр ашиггүй бөгөөд тэдгээрийг салбар байгууллагуудад хуваарилах нь илүү үр дүнтэй²⁶. (б) 62.2-т аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэд төв байгуулж "болно" гэж заасан нь заавал биш, сонголттой зохицуулалт юм. Энэ нь аймаг, сумдын хооронд тусламж, үйлчилгээний хүртээмжийн тэгш бус байдал бий болгоно. Зарим аймагт төв байгуулагдаж харин зарим аймагт байгуулагдахгүй байх эрсдэлтэй. (в) 62.7-д бүтэц, орон тоог Засгийн газар, 62.9-д орон нутгийн хувьд тухайн шатны Засаг дарга батлахаар заасан боловч шаардлагатай санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхойлоогүй.

Хуулийн төслийн 64.1-д тухайн хүний мэдээллийг "өөрөө зөвшөөрсөн тохиолдолд" нийгмийн халамжийн байгууллагад хүргүүлэхээр заасан нь хувийн нууцлалын зарчимтай нийцсэн, хүлээн зөвшөөрөгдөхүйц зохицуулалт. Гэвч 64.4-т "нийгмийн хамгааллын нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ нь... төлбөртэй, төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлтэй байж болно" гэсэн нь хүлээн зөвшөөрөгдөхөд асуудалтай зохицуулалтуудын нэг юм. Мансууруулах бодисын хамааралтай хүмүүс нь ихэвчлэн нийгэм, эдийн засгийн хамгийн эмзэг бүлгийн иргэд (ажилгүй, орон гэргүй, орлого багатай) байдаг тул "төлбөртэй" тусламж, үйлчилгээний хувилбар нь тэднийг үйлчилгээнд хамрагдахад сөргөөр нөлөөлнө.

Хуулийн төслийн 65 дугаар зүйлд зан үйлд нөлөөлөх сургалтыг "албадан" болон "сайн дурын" хэлбэртэй гэж заасан бөгөөд 65.4-т албадан сургалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зохион байгуулахаар заасан. Гэвч хэдий хугацаагаар, ямар шалгуураар "албадан" сургалтад хамруулах нь тодорхойгүй байна.

Хуулийн төслийн 66-70 дугаар зүйл буюу мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн сангийн зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 66-70 дугаар зүйлд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн сангийн зохицуулалтыг дараах байдлаар авч үзсэн.

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн сан
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сангийн төрөл
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийн мэдээллийн сан

²⁶ Steinebach, Y., & Knill, C. (2023). "How policy growth affects policy implementation: bureaucratic overload and policy triage." *Journal of European Public Policy*, 30(1). <https://doi.org/10.1080/13501763.2022.2158208>

- 
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн мэдээллийн сан
 - Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болон хамааралтай хүнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний мэдээллийн сан

Одоогийн 2002 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зохицуулалтад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сангийн талаар зохицуулалт тусгагдаагүй. Гэсэн хэдий ч Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-т энэ талаар тодорхойлсон.

Тодруулбал, тус хөтөлбөрийн 3 дугаар зорилтын 1 дэх үйл ажиллагааг “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, хөтөлбөрийг сурталчлах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх” гэж тодорхойлсон.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас үзвэл 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдөр “Олон улсын мансуурлын эсрэг тэмцэх өдөр”-ийн хүрээнд цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан цахим хэлбэрээр арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан. Тухайлбал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний улмаас хүний бие, эд эрхтэнд учрах хор уршгийн талаар 3 зурагт хуудас, байгууллагын үйл ажиллагаа, шинэ бүтэц орон тоог сурталчилсан агуулгатай 13 зурагт хуудас, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон эцэг, эх, асран хамгаалагч нарт зориулсан зөвлөмж бүхий 2 видео шторкийг бэлтгэн цахим хуудсаар түгээжээ.

Мөн 2020 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 25-ны өдрүүдэд ГЕГ-ын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газартай хамтран Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр, Цагаан хад дахь гаалийн хяналтын бүсэд хяналт шалгалт явуулж, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ухуулга, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд арга хэмжээний хүрээнд улсын хилээр нэвтэрч байгаа хүнд даацын 700 тээврийн хэрэгслүүдэд гаалийн байгууллагатай хамтарсан гэнэтийн үзлэг шалгалтыг албаны нохой, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис илүүлэх багажийн тусламжтайгаар явуулж, жолооч нарт “Мими” гэх бодисын хор уршиг, хууль эрх зүйн мэдээлэл агуулсан 1200 тараах материалыг өгч, Хүнсний мухлаг, дэлгүүр, байгууллага аж ахуй, нэгжийн орох гарах хэсэг, ШТС, хяналтын пост зэрэг газруудад байршуулсан байна.

Ийнхүү мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, хөтөлбөрийг сурталчлах тодорхой хэмжээний арга хэмжээ хийгдсэн боловч мэдээллийн нэгдсэн сан үүсгэсэнтэй холбоотой нэмэлт мэдээлэл тусгагдаагүй байна. Цаашид мэдээллийн нэгдсэн сан бий болгоход анхаарах шаардлагатай.²⁷

Түүнчлэн тус хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын 1 дэх үйл ажиллагааг “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага хооронд ашиглах мэдээллийн нэгдсэн сан бий болгох” гэж тодорхойлсон.

²⁷ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, “Эс Ай Си Эй” ХХК, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ”, (УБ, 2023), 38-39 дэх тал.



Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт тухайн байдлаар тодорхойлсон. Цагдаа, тагнуул, хил, гааль, шүүхийн шийдвэр биелүүлэх, эрүүл мэндийн байгууллага зэрэг чиг үүргийн байгууллагууд хооронд гэмт хэрэг, зөрчлийн болон сэжигтэй этгээд /хэрэглэгч, донтогч, тээвэрлэгч, зохион байгуулагч, хорих болон хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн г.м/ бүлэг, бөөгнөрөл, байр байгууламжийн талаар мэдээ, мэдээллийг шуурхай солилцох, мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээллийг байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглуулах зорилгоор 9 байгууллагаас шаардлагатай 24 мэдээлэл, судалгааг нэгтгэж, 12 дэд сан бүрдүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/27 дугаар тушаалаар байгуулагдсан “Ажлын хэсэг”-ээс Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, мэдээллийн нэгдсэн санг боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулж, зөвлөмжийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан арга хэмжээний хүрээнд энэ ажлыг тэвчиж болох зардал гэж үзэн санхүүжилтийг Сангийн яамнаас буцаан татсаны улмаас зохион байгуулаагүй.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад байгууллага бүр өөрийн ашигладаг тодорхой мэдээллийн сантай боловч хууль хүчний байгууллага бүрийг хамарсан нэгдсэн мэдээллийн сан байхгүй байна.

Нэгдсэн мэдээллийн сантай болох ажил хийгдэх үндэс тавигдсан боловч нийгэм эдийн засгийн хүнд байдалтай холбоотой хэрэгжээгүй тул дээрх үйл ажиллагааг “эрчимжүүлэх шаардлагатай” хэмээн үзэж байна.²⁸

Дээрхээс дүгнэвэл, хуулийн төсөлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сангийн зохицуулалтыг тусгаж байгаа нь одоогийн нөхцөл байдалд тохирсон, бодлогын баримт бичигт нийцсэн, үр дүнтэй зохицуулалт байгаа боловч урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, сурталчлах үйл ажиллагааг мөн мэдээллийн санд оруулах талаар анхаарч авч үзэх шаардлагатай.


Мөн Европын Мансууруулах бодисын хяналтын төв (EMCDDA)-ын порталд тэмдэглэснээр мэдээллийн сан бүрдүүлэхдээ хувийн мэдээллийн хамгаалалтын стандартыг баримтлах, мэдээллийн хамгийн бага байдлын (data minimisation) зарчим хэрэглэх, нэвтрэх эрхийг чиг үүргээр ялгах (role-based access control) зэрэг зарчмыг тодорхой заасан.²⁹

Хуулийн төслийн холбогдох зохицуулалтуудын хувьд дараах асуудлууд гарч болзошгүй:

Нэгт, Хуулийн төсөлд зөвшөөрөл эзэмшигч, эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, мал эмнэлгийн байгууллага, аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар зэрэг олон тооны этгээдэд улирал тутмын нарийвчилсан тайлан гаргах үүрэг хүлээлгэсэн. Тухайлбал: зөвшөөрөл эзэмшигчийн тайлан (21.1 — улирал тутам), эмийн сангийн тайлан (28.6 — улирал тутам), эрүүл мэндийн байгууллагын тайлан (29.5 — улирал тутам), мал эмнэлгийн тайлан (29.10 — улирал тутам), ургамал түүгчийн тайлан (30.5 —

²⁸ Мөн тэнд, 48-49 дэх тал.

²⁹ EMCDDA (European Monitoring Centre for Drugs and Drug Addiction), Best Practice Portal



улирал тутам), эрх бүхий байгууллагуудын тайлан (31.3 — улирал тутам), жорын зарцуулалтын тайлан (27.9 — улирал тутам). Энэ бүх тайланг цаасан болон цахим хэлбэрээр хөтлөх нь ялангуяа жижиг, дунд хэмжээний эмийн сан, орон нутгийн эмнэлгүүдэд ихээхэн хүнд ачаалал юм.

Хоёрт, Хуулийн төслийн 70.1.1-д "мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай нь тогтоогдсон болон тогтмол хэрэглэдэг хүний бүртгэл мэдээлэл" цуглуулахаар заасан нь мансууруулах бодис хэрэглэгчдийн "нэрсийн жагсаалт" (registry) бий болгох утгатай. БНХАУ-ын 2008 оны Мансуурлын эсрэг хуульд тулгуурласан Динамик хяналтын тогтолцоо нь мансуурлын хэрэглэгчдийг бүртгэж, тэдний хөдөлгөөнийг хянадаг бөгөөд олон улсын хүний эрхийн байгууллагууд үүнийг хувийн нууцлал болон нэр төрийг зөрчдөг гэж шүүмжилсэн байдаг³⁰. Тус бүртгэл нь 58 дугаар зүйлд заасан "эрх зүйн байдлыг дордуулахгүй" зарчимтай шууд зөрчилдөх эрсдэлтэй. Хэрэв тухайн хүний нэр бүртгэлд орсон бол ажил олгогч, даатгалын компани, боловсролын байгууллага нь энэ мэдээлэлд нэвтрэх боломж авч болзошгүй мөн тухайн хүний нийгмийн нэр хүнд унах, ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэл нэмэгдэнэ.

Хуулийн төслийн 71 дүгээр зүйл буюу мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

2002 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд урьдчилан сэргийлэх нийтлэг үүрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сурталчилгааны зохицуулалтыг тусгажээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар болон Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг зэрэг бусад төрийн болон төрийн бус байгууллагууд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхтэй явуулж байна. Гэвч энэ төрлийн асуудал эрхэлсэн байгууллагууд хоорондын мэдээлэл солилцох байдал дутмаг байна.³¹


Тус хуулийн дээрх зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээг "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" судалгааны тайлангийн "3.8.1.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа" хэсгээс үзнэ үү.

Дээрх судалгааны үр дүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа хангалтгүй гэж дүгнэжээ.

Иймд энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудад тасралтгүй шинэчлэл, сайжруулалт хийх шаардлагатай. Мөн энэ төрлийн сургалтад хамрагдсан, туршлагатай мэргэжлийн боловсон хүчин тогтвортой байх нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөтэй юм. Хуулийн

³⁰ Lin, M., & Amon, J.J. (2022). "No Exit: China's State Surveillance over People Who Use Drugs." Health and Human Rights Journal, 24(1). <https://www.hhrjournal.org/2022/06/08/no-exit-chinas-state-surveillance-over-people-who-use-drugs/>

³¹ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" ХЗҮХ, (УБ, 2024).



төслийн зохицуулалтад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааны талаар нарийвчлан зохицуулсан нь дээрх асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй зохицуулалт болсон байна. Түүнчлэн тухайн төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүний хөрөнгө, орлогыг хураах, ял, шийтгэлийн дараа хяналт тавих, гадаад улсын холбогдогчийг албадан гаргах зэрэг урьдчилан сэргийлэхэд үр нөлөө бүхий зохицуулалтуудыг тусгасан байна.

Хуулийн төслийн 71 дүгээр зүйл нь "Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ" гэсэн гарчигтайгаар хэд хэдэн чухал зохицуулалтын агуулсан байна. Тус зүйлийг хамрах хүрээний зохицуулалтын шинж чанараар нь дараах байдлаар ангилан үзэж болно:

71.1. Хилийн боомт дээрх сэрэмжлүүлгийн заавал тавигдах шаардлага дөрвөн хэлээр мэдээлэл байрлуулах үүрэг;

71.2. Хүн, хуулийн этгээдэд хориглолт тогтоосон үйл ажиллагааны жагсаалт;

71.3. Харилцаа холбооны байгууллагуудад чиг үүрэг, хариуцлага хүлээлгэсэн зохицуулалт;

71.4. Тус байгууллагуудад тайлагнах үүрэг тогтоосон заалт;

71.5. Сургалт, арга хэмжээний хэрэгжүүлэгч байгууллагуудыг тодорхойлсон заалт.

Зохицуулалтын зан шинжийн хувьд тус зүйл нь нэгэн зэрэг дараах хоёр ялгаатай зохицуулалтын хэлбэрийг агуулна: захиргааны байгууллагад үүрэг хүлээлгэх (71.1, 71.3, 71.4, 71.5) болон хувийн этгээдэд хориглолт тогтоох (71.2). Эдгээр хоёр хэлбэр нь үр нөлөөний судалгааны хүлээн зөвшөөрөгдөх байдлын шалгуурт хэрхэн тусах талаар тус тусад нь шинжлэх шаардлагатай.

Хуулийн төслийн 71.1 дэх хэсгийн дагуу мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаарх сэрэмжлүүлгийг нэвтрэхээс өмнөх хэсэгт байрлах мэдээллийн самбар болон гаалийн мэдүүлэгт монгол, англи, орос, хятад хэлээр бичсэн байхыг заавал шаарддаг. Энэ нь практик хэрэгжилтийн хүрээнд тодорхой зохион байгуулалт, санхүүжилт, техникийн шаардлага бий болгоно.

Тус заалт нь зорчигч болон нэвтэрч байгаа этгээдэд урьдчилан мэдэгдэх ил тод байдлын зарчмыг хангаж, хариуцлагын талаарх ойлголтыг сайжруулахад дөхөм болно. Олон улсын нисэх онгоцны буудал, хилийн боомтод ийм мэдэгдэл байршуулах нь олон улсад тогтсон практик юм.³²

Хуулийн төслийн 71.2 дэх хэсэг нь гурван дэд заалт агуулна. Эдгээр дэд заалт тус бүр нь аж ахуй, байгууллага, хэвлэл мэдээлэл, урлаг, боловсрол зэрэг олон салбарт шууд нөлөө үзүүлэх ач холбогдол бүхий хориглолтыг агуулдаг.

Хуулийн төслийн 71.2.2 дэд заалтад дараах материалыг "хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим орчинд, бусдад түгээх, сурталчлах" үйлдлийг хориглосон байна: мансааруулах бодис *"бэлтгэх, боловсруулах, үйлдвэрлэх, хэрэглэх, тариалахыг заах"* болон хууль бус эргэлт, хэрэглээний талаарх агуулга бүхий *"кино, тоглолт, дуу авиа, дүрс бичлэг, хуурцаг, ном товхимол, зураг"*-ыг хамрана.

³²OECD, "Guiding Principles for Regulatory Quality and Performance" (OECD, 2005), 3.



Хуулийн тодорхойлолтын хувьд нэгдүгээрт, "кино" хэмээн заасан нь уран сайхны кино дахь дүр зурагч, мэдээллийн кино, баримтат кино, боловсролын кино зэргийг ялгалгүй хамарч болох суурь тодорхойгүй хориглолт юм.

Хоёрдугаарт, "мэдээлсэн" ба "сурталчилсан" гэсэн ялгааг тогтоогоогүй нь хууль хэрэглээний хүрээнд асуудал үүсгэнэ. Зарим орнуудын практикт (Harm reduction) буюу "хор хөнөөлийг бууруулах" сургалт нь хэрэглэгчдэд аюул, эрсдэлийг мэдэгдэх зорилгоор дэлгэрэнгүй мэдээлэл ашигладаг бөгөөд тус заалтад хамаарах боломжтой. Иймд боловсролын агуулгыг "мэдээлсэн" гэдэг нь эрүүл мэндийн боловсролын үйл ажиллагаанд саад болох эрсдэлтэй байна.

Хуулийн төслийн 71.2.3-д "мансааруулах, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, зураг, дүрс, тэмдгийг аливаа сурталчилгаа болон кино, тоглолт, дуу авиа, дүрс бичлэг, хуурцаг, ном товхимол, зурагт оруулах, ашиглах"-ыг хориглосон байна. Тус заалтын зохицуулалт нь дараах аж ахуйн нэгж, байгууллагуудад хамаарна:

1. Кино, урлаг, соёлын байгууллагууд: Гэмт хэрэг, нийгмийн асуудлыг дүрсэлсэн урлагийн бүтээлд тухайн бодисын "нэр, зураг, дүрс" гарах нь баримтат хандлага, уран сайхны тайлбарын нэг хэсэг;

2. Эмийн компани, эрүүл мэндийн байгууллагууд: Эмийн сурталчилгааны болон боловсролын материалд холбогдох бодисын нэрийг дурдах хэрэгцээ бий;

3. Боловсролын байгуулага: Мансааруулах бодисын хор хөнөөлийн тухай сурах бичиг, гарын авлага дахь зураг, схем, нэр томьёо.

Хуулийн хэрэглээний хувьд "аливаа сурталчилгаа" гэсэн өргөн нэр томьёог зохицуулалтын зорилгод харгалзан тусгайлан тодорхойлоогүй нь учир дутагдалтай байна.

Хуулийн төслийн 71 дүгээр зүйлийн 71.2.3-т хориглолтын зааж өгөхдөө үнэмлэхүй хориглосон байна. Өөрөөр хэлбэл, "зорилго дэмжих" болон "зорилго эсэргүүцэх" ялгааг тооцоогүй. Олон улсын практикт ийм хориглолтыг *"контекст-хамаарсан"* (context-sensitive) байдлаар, өөрөөр хэлбэл зорилго, зориулалтаар нь ялгах замаар зохицуулдаг. Тиймээс тус заалт нь боловсролын, урьдчилан сэргийлэх, баримтат (documentary) зорилго бүхий агуулгыг "сурталчилгаа" гэсэн нэг ойлголтоор хамруулж болзошгүй байна.

Хуулийн төслийн 71.3 дэх хэсэгт Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага, Харилцаа холбооны зохицуулах хороо, оюуны өмчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагад дараах чиг үүрэг хүлээлгэсэн байна: мансааруулах бодисыг *"заах, мэдээлсэн, ил болон далд сурталчилсан"* кино, дүрс бичлэг, ном товхимол, хэвлэмэл зургийг харилцаа холбооны сүлжээ ашиглан түгээх, сурталчлах үйл ажиллагааг таслан зогсоох, хяналт тавих хэмээн тусгаж өгсөн. Тус зохицуулалтаас дараах асуудлууд гарах боломжтой. Үүнд:

Нэгдүгээрт, "далд сурталчилсан" хэмээн заасан нь хуулийн нарийн тодорхойлолт шаарддаг ойлголт юм. Олон улсын практикт "далд" (covert) сурталчилгааны тодорхойлолт нь зориуд нуусан байхыг ойлгодог боловч тус хуульд энэ ялгааг тусгаагүй нь байгууллагуудад хэт өргөн дискрецийн эрх олгоно.

Хоёрдугаарт, "ил болон далд" сурталчилгааг нэгэн зэрэг хоёуланг нь хориглосон нь хэт өргөн хориглолт тогтоосон байж болзошгүй.

3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Энэхүү шалгах хэрэгслийг хэрэглэж хуулийн төслийн үр нөлөөг үнэлснээр хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоож, тэдгээрийг арилгаж, тухайн хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулна. Энэ хүрээнд хуулийн төслийн холбогдох зохицуулалтуудад дүн шинжилгээ хийнэ.

Хүснэгт 12. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт хуулийн зорилтыг "мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэхтэй холбогдсон харилцааг зохицуулах" гэж тодорхойлжээ. Хуулийн төслийн бүтэц, агуулга нь энэхүү зорилтод нийцсэн гэж дүгнэж байна. Тодруулбал, (1) урьдчилан сэргийлэх зорилтыг 8 дугаар бүлгийн 71 дүгээр зүйл, 6 дугаар бүлгийн 58–65 дугаар зүйлүүд; (2) эрүүл мэнд хамгаалах зорилтыг 4 дүгээр бүлгийн 23–42 дугаар зүйл (эргэлтийн нарийвчилсан зохицуулалт); (3) эргэлтэд хяналт тавих зорилтыг 3, 5, 7 дугаар бүлгийн зохицуулалтууд (зөвшөөрөл, төрийн байгууллагын тогтолцоо, мэдээллийн сан); (4) хууль бус эргэлттэй тэмцэх зорилтыг 74 дүгээр зүйлийн хариуцлагын заалт болон дагалдах Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл (20.20–20.31 дүгээр зүйл) , Зөрчлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл тус тус хангаж байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт хууль тогтоомжийн бүрэлдэхүүнийг дараах хуулиудаар тодорхойлжээ: Монгол Улсын Үндсэн хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль. Жагсаасан хуулиуд нь тухайн харилцаанд хамаарах хууль мөн гэж үнэлж байна. Гэвч Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн тайлбар дугаарыг "3" гэж бичсэн нь "Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль"-ийн тайлбар дугаартай давхардсан (хоёулаа "3" тайлбар дугаартай). Энэ нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн тайлбар дугаарыг "9" эсхүл өөр дугаараар олгох замаар засварлах шаардлагатай; мөн Гаалийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль зэрэг хуулийн төсөлд шууд эш татсан хуулиудыг жагсаалтад оруулаагүй байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд 21 нэр томьёоны тодорхойлсон бөгөөд эдгээр нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн нэр томьёог илүү нарийвчлан тусгасан байна. Тухайлбал, "мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис" (4.1.1), "мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамал" (4.1.2), "угтвар бодис" (4.1.3), "шинэ төрлийн бодис" (4.1.4), "эргэлт" (4.1.5), "урвуулан хэрэглэх" (4.1.19) зэрэг нэр томьёонуудыг шинээр тодорхойлжээ. Нэр томьёоны уялдааны хувьд дараах асуудлууд ажиглагдаж байна: Нэгд, хуулийн төслийн гарчиг нь "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай" гэсэн бөгөөд 2002 оны хүчин төгөлдөр хуулийн нэртэй адил юм. Гарчиг нь хуулийн бодит хамрах хүрээг (хууль

	ёсны болон хууль бус эргэлтийг аль алиныг нь) зөв илэрхийлж байна. Хоёрт, "эм" гэсэн нэр томьёо (4.1.20) нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.1, Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 4.1.1-д заасныг иш татсан нь зөв, уялдаатай. Гуравт, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.4, 4.1.5-д нэр томьёоны тодорхойлолтыг шинэчлэн найруулахаар заасан нь хуулийн төсөлтэй нэр томьёоны уялдааг хангахад чиглэсэн зөв арга хэмжээ юм.
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн дотоод нийцлийн хувьд хэд хэдэн зөрчил илэрлээ. Нэгд, дугаарлалтын алдаа: 11 дүгээр зүйлийн 11.1.4 дугаар 2 удаа давтагдсан бөгөөд "мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис худалдах буюу ханган нийлүүлэх" болон "мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эм олгох эмийн сангийн үйлчилгээ эрхлэх" гэсэн хоёр ялгаатай заалтад ижил 11.1.4 дугаар олгожээ. Үүний улмаас 26.2-т "11.1.3-т заасан зөвшөөрлийн үндсэн дээр" гэж заасан нь буруу эшлэсэн байна. (11.1.3 нь экспортлох зөвшөөрөл, харин худалдах зөвшөөрлийн 11.1.4 байх ёстой). Гуравт, 42.15-д "Тариалангийн газар эзэмшигч, ашиглагч нь энэ хуулийн 42.15-д заасан үүргээ биелүүлээгүй бол" гэж эш татсан нь логик алдаа бөгөөд 42.14 дэх хэсгийг эшлэх нь зүйтэй. Бусад хуультай нийцлийн хувьд, хуулийн төслийн зохицуулалт нь Зөвшөөрлийн тухай хууль -ийн ерөнхий журамтай зөрчилдөхгүй, харин ч Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбоотой харилцааг тусгайлан зааж, дагалдах хуулийн төсөлөөр нэмэхээр тусгажээ. Энэ нь зохистой, нийцлийг хангасан шийдэл юм
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийн 5 дугаар бүлэгт (43–57 дугаар зүйл) хуулийг хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоог нарийвчлан тусгажээ. Тухайлбал: Улсын Их Хурал (44.2), Засгийн газар (44.3), Үндэсний хороо (45), хууль зүйн (46), гадаад харилцааны (47), эрүүл мэндийн (48), боловсролын (49), байгаль орчны (50) асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тагнуулын (51), цагдаагийн (52), хил хамгаалах (53), гаалийн (54), эм, эмнэлгийн хэрэгслийн болон мал, амьтны эрүүл мэндийн (55), шүүхийн шийдвэр гүйцэтгэх (56), нутгийн удирдлагын (57) байгууллагуудын чиг үүргийг тодорхойлжээ. Энэ нь хэрэгжүүлэх этгээдийг хангалттай тодорхой, нарийвчилсан байдлаар тусгасан гэж үнэлж байна. Гэвч зарим асуудлыг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой заагаагүй байна. Тухайлбал, хуулийн төслийн 6.3-д шинэ төрлийн бодисыг ангилалд оруулах санал "хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эсхүл эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор" гэж заасан нь "эсхүл" гэсэн холбоос нь аль нэгээс ч гаргаж болно гэсэн утгатай бөгөөд хоёр сайд хоорондын уялдаа, зөвшилцөх журмыг тодорхой болгох шаардлагатай.
Хуулийн төсөлд байх	Тус хуулийн төсөлд тусгах шаардлагатай байсан зарим зохицуулалтыг орхигдуулсан байна. Тухайлбал, хуулийн төсөлд мансууруулах, сэтгэцэд

шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	нөлөөт бодисын хамааралтай хүний сэтгэц-нийгмийн сэргээн засах үйлчилгээг "сайн дурын" үндсэн дээр (58–64 дүгээр зүйл) үзүүлэхээр заасан нь оновчтой боловч, тусламж, үйлчилгээний чанарт тавих хяналтын механизм, магадлан итгэмжлэлийн шалгуурыг нарийвчлан тусгаагүй. Хуулийн төсөлд цахим жор бичих, олгох зохицуулалт тусгагдаагүй бөгөөд одоогийн цахимжилтын хөгжлийг харгалзахад цахим жор бичилтийн нарийвчилсан зохицуулалтыг Эрүүл мэндийн сайдын А/408 журмын 5.1-д "цаасан эсвэл цахим жор" гэж тусгасан боловч хуулийн төсөлд энэ талаар хангалттай зохицуулалт ороогүй.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төслийн 5 дугаар бүлэгт (43–57 дүгээр зүйл) 15-аас дээш төрийн байгууллагын чиг үүргийг тусгасан бөгөөд эдгээрийн хооронд зарим давхардал ажиглагдаж байна: Нэгд, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын (46) болон цагдаагийн байгууллагын (52) чиг үүрэг зарим тохиолдолд давхардаж байна. 46.1.1-д "гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах", 52.1.1–52.1.2-т "гэмт хэрэг, зөрчил гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах" болон "гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох" гэж ижил төстэй чиг үүрэг тусгасан. Мөн 46.1.5-д "мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих чиг үүрэг бүхий харьяа байгууллагыг... хангах ажлыг зохион байгуулах" гэж заасан нь цагдаагийн байгууллагыг хамарсан ерөнхий чиг үүрэг юм. Хоёрт, гаалийн байгууллага (54) болон хил хамгаалах байгууллагын (53) хоорондын чиг үүрэг нь улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих хэсэгт давхарч байна. 53.1.2-т "тээврийн хэрэгсэлд үзлэг хийх явцад илэрсэн тохиолдолд эрх бүхий этгээдэд мэдэгдэх" гэж, 54.1.1-д "мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх, таслан зогсоох" гэж заасан нь чиг үүргийн зааг ялгааг тодорхой болгох шаардлагатай болохыг харуулж байна.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж шинээр тогтоосон заалт тусгагдаагүй бөгөөд энэ нь зохистой юм. Зөвшөөрлийн хураамжтай холбоотой асуудлыг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулахаар хөндлөнгөөс эш татсан нь зүйтэй.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт (11–22 дугаар зүйл) зөвшөөрлийн нарийвчилсан зохицуулалтыг тусгасан бөгөөд дагалдах Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд 1.32, 12.15–12.22, 13.21–13.28-д шинэ заалтуудыг нэмж, одоогийн 13.17–13.19 дэх заалтыг хасахаар заажээ. Энэ нь Зөвшөөрлийн тухай хуулийн шаардлагад бүрэн нийцсэн арга хэмжээ юм. Зөвшөөрлийн тухай хуулийн 2022 оны шинэчилсэн найруулгаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001) хүчингүй болсон тул одоо бүх тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулах шаардлагатай.
Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээнд заасан хүний эрхийг	Хуулийн төсөлд хүний эрхийг хязгаарласан хэд хэдэн зохицуулалт тусгагдсан бөгөөд эдгээр нь нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор хуульчлагдсан хязгаарлалт юм. Тухайлбал, хуулийн 8.1-д эргэлтэд оруулахыг хориглох, 9.1-д шинэ төрлийн бодисыг хориглох, 63 дугаар зүйлд албадан эмчилгээ, 72 дугаар зүйлд гадаад иргэнийг албадан гаргах зэрэг. Эдгээр хязгаарлалт нь Үндсэн хуулийн 16.2 (амьд

хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	явах, эрүүл мэндээ хамгаалуулах эрх), 19.1 (хүний эрхийг зөвхөн хуулиар хязгаарлах) дүгээр зүйлүүдтэй нийцсэн. Мөн НҮБ-ын гурван конвенцийн шаардлагын хүрээнд авах арга хэмжээ юм. Хуулийн төслийн 5.1 дүгээр зүйлд "хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хууль ёсны ашиг сонирхлыг нь хүндэтгэх" зарчмыг баримтлахаар заасан нь хүний эрхийн тэнцвэрийг хангахад чиглэсэн байна.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй. Зөвшөөрлийн тогтолцоо нь нээлттэй бөгөөд хуульд дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан аливаа хуулийн этгээдэд зөвшөөрөл олгохоор тусгасан. Гэвч мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын зах зээл нь мөн чанартаа нээлттэй зах зээлийн бус, хатуу зохицуулалттай салбар учраас өрсөлдөөний асуудал энэ салбарт хамааралгүй.
Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авлигын эрсдэлийг бүрэн арилгасан гэж хэлэх боломжгүй. Зарим зохицуулалт нь авлигын эрсдэлийг бий болгох магадлалтай: Тухайлбал, зөвшөөрлийн олон шат дамжлага (12–14 дүгээр зүйл) нь зөвшөөрөл олгогч этгээдийн захиргааны шийдвэр гаргалтад хэт их эрх мэдэл олгож байгаа нь авлигын эрсдэлийг нэмэгдүүлж болно. Гэвч энэ нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хяналтын тусгай шинж чанартай холбоотой, шаардлагатай хатуу хяналтын арга хэмжээ юм. Түүнчлэн, хуулийн төслийн зохицуулалтуудад "эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэн" (17.1, 41.2, 41.3 зэрэг) гэж тусгасан боловч дүгнэлт гаргах байгууллагын бие даасан байдал, шударга ёсыг хангах нэмэлт баталгааг тусгаагүй. Мөн хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.3-д "нэн даруй шийдвэрлэнэ" гэж заасныг өөрчилж хугацааг тодорхой байдлаар тусгах нь зүйтэй. Ийнхүү хугацааг тодорхой байдлаар тусгах нь авлига, хүнд суртлыг бий болгохгүй байхад чухал нөлөөтэй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийн 74 дүгээр зүйлд "Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж заажээ. Энэ нь бланкет хэм хэмжээ бөгөөд хариуцлагын нарийвчилсан зохицуулалтыг дагалдах хуулийн төслүүдэд тусгасан байна. Тус хуулийн дагалдах хуулийн төслийн үр нөлөөг тусад нь тооцсон бөгөөд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн хэсгээс энэ талаар дэлгэрүүлж үзнэ үү.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу (1) зорилгод хүрэх байдал, (2) практикт хэрэгжих боломж, (3) ойлгомжтой байдал, (4) хүлээн зөвшөөрөгдөх байдал, (5) харилцан уялдаа гэсэн 5 шалгуур үзүүлэлтээр үнэлж, дараах дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

"Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хуулийн зорилтын нийцлийн талаар. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тодорхойлсон зорилт нь хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагаврыг бүхэлд нь оновчтой байдлаар тусгасан, зохицуулах харилцааг бүхэлд нь хамруулсан тул хуулийн зорилгод нийцэж байна гэж үнэлэв. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2002 оны хуулийн зорилтын уламжлалт шинж чанарыг агуулсан хэдий ч "хүн амын удмын санг хамгаалах" чиглэлийг тусгаагүй байна. Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.1.3.4-т "архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна" гэж заасныг харгалзвал энэ асуудлыг эргэн авч үзэх нь зүйтэй. Мөн хуулийн зорилтод "хүн амын эрүүл мэндийг хамгаалах" гэж заасан нь мал, амьтны эрүүл мэндийг хамаарахгүй мэт боловч хуулийн 3.1 дэх хэсэгт мал, амьтны эмийн зохицуулалтыг тусгасан байгаа нь зорилтын хамрах хүрээг тодруулах шаардлагатай болохыг харуулж байна.

- Хуулийн төслийн бүтцийн талаар. Хуулийн төсөл нь нийтдээ 9 бүлэг 75 зүйлээс бүрдэж байгаа нь одоогийн 17 зүйлтэй хуулиас илүү дэлгэрэнгүй, системчилсэн бүтэцтэй бөгөөд хуулиар зохицуулах харилцааг бүхэлд нь хамарсан гэж дүгнэв.

- Төрөөс баримтлах бодлогын талаар (Хуулийн төслийн 43 дугаар зүйл). Хуулийн төслийн 43 дугаар зүйлд тусгасан зургаан бодлогын чиглэл (43.1.1-43.1.6) нь хуулийн нэгдүгээр зүйлийн дөрвөн зорилтыг (урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах, эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх) бүрэн хамарсан бөгөөд Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор баталсан "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-тэй нийцсэн. Гэвч бодлогын чиглэлүүд нь хэрэгжилтийн гарцын шалгуур тогтоогоогүй, "хэрэглэгч" болон "хэрэгтэн"-ийн ялгааг бодлогын хувьд тодорхойлоогүй, шинэ төрлийн мансууруулах бодис (NPS)-тай тэмцэх механизм тусгайлан дурдагдаагүй.

- Байгууллагын тогтолцооны талаар (Хуулийн төслийн 44 дүгээр зүйл). Хуулийн төслийн 44 дүгээр зүйлд тусгасан дөрвөн шатлалт тогтолцоо (Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний хороо, тусгай чиг үүргийн байгууллагууд) нь Монгол Улсын засаг захиргааны бүтэцтэй нийцсэн байна. Засгийн газрын 8 чиглэлт чиг үүрэг (44.3.1-44.3.8) нь UNODC-ийн 2024 оны тайлан, M-LET санаачилга, OGP-ийн 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нийцэж байгааг судалгаагаар тогтоов. Гэхдээ бүрэн эрх тус бүрийн хэрэгжилтийн хугацаа, байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам, хяналт-шинжилгээ, үнэлгээний журам зэргийг дагалдах захиргааны актуудаар нарийвчлан зохицуулах шаардлагатайг анхаарах шаардлагатай.

Зөвлөмж

1. Хуулийн зорилтод "хүн амын удмын санг хамгаалах" чиглэлийг тусгах эсэхийг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.3.4-д нийцүүлэн эргэн авч үзэх;
2. Хуулийн зорилтын хамрах хүрээнд мал, амьтны эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан (3.1) бол зорилтод энэ талаар тодруулга нэмэх талаар дахин авч үзэх;
3. Хуулийн төслийн 43 дугаар зүйлд "хэрэглэгч" болон "хууль бус эргэлтийн гэм буруутай этгээд"-ийн ялгааг тодорхой заагалж, шинэ төрлийн синтетик мансууруулах бодис (NPS)-тай тэмцэх механизмыг нэмэх;
4. Бодлогын зорилт тус бүрд хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт тогтоох;
5. Хуулийн төслийн 44 дүгээр зүйлийн бүрэн эрх тус бүрийн хэрэгжилтийн хугацаа, байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам, хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг тогтоосон дагалдах захиргааны актуудыг батлах.

"Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Тусгай зөвшөөрлийн зохицуулалт (Хуулийн төслийн 11-22 дугаар зүйл). Хуулийн төслийн 11-22 дугаар зүйлийн зохицуулалт нь одоогийн Эрүүл мэндийн сайдын А/408 дугаар тушаалын журмын хэрэгжилтийн практикт суурилсан тул нийтдээ практикт хэрэгжих боломжтой гэж үнэлэв. Тодруулбал, зөвшөөрөл шаардагдах 8 төрлийн үйл ажиллагааг (11.1) Журамд баталгаажуулсан, Монгол Улсад импортлох тусгай зөвшөөрөлтэй 7 байгууллага, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 2 байгууллага ажиллаж байна. Гэвч судалгаагаар дараах практик хүндрэлүүд тогтоогдов: (а) "нэн даруй" (20.1.4), "тогтмол сургах" (12.2.2), "шаардлагатай техник хэрэгсэл" (12.2.5) зэрэг нэр томьёо хугацааны болон техник хэрэгслийн тодорхой хязгааргүй, субъектив байдлаар техник хэрэгслийг шаардах нөхцөлийг бүрдүүлэх; (б) зөвшөөрөл эзэмшигч хоёр байгууллагад (эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан байгууллага ба цагдаагийн төв байгууллага) нэгэн зэрэг мэдэгдэх давхар тайлагналын ачаалал; (в) мэдэгдлийн хугацааг 7 хоногоос 3 өдрөөр богиносгосон (14.2) нь цахимжуулалтгүй нөхцөлд хүндрэлтэй; (г) зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацааны дээд хязгаарыг тогтоогоогүй (17.2); (д) 19.1.2-д "хариуцлага хүлээсэн" гэдэг нь эрүүгийн, эсхүл зөрчлийн шийтгэлийг ойлгох эсэх нь тодорхойгүй.

- Үйл ажиллагааны зохицуулалт (Хуулийн төслийн 23-42 дугаар зүйл). Судалгаагаар тогтоосон дөрвөн ерөнхий дүгнэлт: Нэгд, хуулийн төслийн зохицуулалт нь одоогийн хуулиас нарийвчилсан, бодисын эргэлтийн бүхий л үе шатыг хуулийн түвшинд зохицуулсан. Ре-экспортын зохицуулалт (24.5-24.6), мал, амьтны эмийн тусгай зохицуулалт (28.8-28.10, 29.8-29.10, 38), зэвсэгт хүчний зохицуулалт (33) зэрэг шинэ агуулгууд бодит хэрэгцээнд нийцсэн. Хоёрт, хэрэгжүүлэх этгээд тодорхой, хэрэгжих суурь нөхцөл хангагдсан. Гуравт, хилийн боомт бүрд шинжилгээний лаборатори бүрдүүлэх (25.4), зориулалтын тээврийн хэрэгслийг тоноглох (40.5), орон нутгийн эмнэлгүүдэд дохиолол, хяналтын систем суурилуулах (39.2.2), 1.5 сая ам.км нутаг дэвсгэрт ургамал устгах ажлыг зохион байгуулах (42) зэрэг зохицуулалтууд нь улсын болон орон нутгийн төсвөөс нэмэлт санхүүжилт шаардана. Дөрөвт, хуулийн ихэнх зүйлд мэдэгдэх, тайлагнах шаардлага тусгасан нь тайлагналын ачааллыг нэмэгдүүлэхээр байна.



- Байгууллагын тогтолцооны зохицуулалт (Хуулийн төслийн 45-57 дугаар зүйл). Хуулийг хэрэгжүүлэх этгээд (15-аас дээш төрийн байгууллага) хангалттай тодорхой тусгагдсан. Гэвч олон байгууллага хоорондын мэдээлэл солилцох цогц механизм бүрдүүлэх, зарим байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах шаардлагатай.

Зөвлөмж

1. "Нэн даруй", "тогтмол сургах", "шаардлагатай техник хэрэгсэл" зэрэг нэр томъёонд цаг хугацааны хязгаар болон техник хэрэгслийн шалгуурыг тогтоох;
2. Нэгдсэн цахим тайлангийн системийг (66-70 дугаар зүйлтэй уялдуулан) бий болгох хуваарийг хуулийн шилжилтийн үеийн зохицуулалтд тодорхой тусгах;
3. Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацааны дээд хязгаар тогтоож (17.2), хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан тохиолдолд шилжилтийн үеийн тусгай зохицуулалт нэмэх (18.2, 18.3);
4. Хуулийн төслийн 19.1.2 дахь "хариуцлага хүлээсэн" гэдэг ойлголтын хамрах хүрээг тодорхой болгох;
5. Хилийн боомтод лаборатори байгуулах шаардлага (25.4)-ыг шатлан хэрэгжүүлэх хуваарь тогтоох;
6. Мэдэгдлийн хугацааг цахим тогтолцоо нэвтрүүлэх хүртэл уян хатнаар зохицуулах;
7. Хадгалалтын техник шаардлага (39.2), тээвэрлэлтийн тоног төхөөрөмж (40.5) зэрэг зохицуулалтыг шатлан хэрэгжүүлэх хугацаатай болгох.


"Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн дүгнэлт, зөвлөмж

Дүгнэлт

- Ангиллын зохицуулалт (Хуулийн төслийн 6 дугаар зүйл). Хуулийн төслөөр тогтоосон дөрвөн шатлалт ангилал ("А"- "Г") нь НҮБ-ын 1961, 1971 оны конвенцуудын жагсаалтын бүтэцтэй зарчмын хувьд нийцсэн. Хуулийн төслийн 6.3-т шинэ бодисыг "нэн даруй" ангилалд оруулах зохицуулалт нь синтетик каннабиноид, фентанилын аналог зэрэг бодисуудад уян хатан хариу авах боломж олгоно. Гэвч ангиллын жагсаалтыг Засгийн газар батлахаар заасан (6.2) нь мэргэжлийн бие даасан шийдвэр гаргах механизмыг хуулийн түвшинд тогтоогоогүй. Герман Улсын BtMG хуулийн загвараар мэргэжлийн зөвлөх хорооны (Sachverständigenausschuss) оролцоог хуульчлах нь олон улсын жишигт нийцнэ.

- Эрт илрүүлэх зохицуулалт (Хуулийн төслийн 58 дугаар зүйл). Хуулийн төслийн 58.4-т "эрх зүйн байдлыг дордуулахгүй", 58.5-д мөрдөн шалгахад мэдээлэл ашиглахыг хориглосон зохицуулалт нь ДЭМБ-ын стандарт (2020), Португалын загвартай нийцсэн. Гэвч Хуулийн төслийн 58.2-т өсвөр насныхны (16-17 нас) хувьд эцэг, эхийн хүсэлтээр шинжилгээ хийх нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийн 3, 12 дугаар зүйлтэй зөрчилдөх эрсдэлтэй; ажил олгогч, даатгалын компани зэрэг гуравдагч этгээдийн мэдээлэл ашиглах боломжийг хуулиар хааж өгөөгүй; хөдөө орон нутагт магадлан итгэмжлэгдсэн лаборатори байхгүй, хязгаарлагдмал тул хүртээмж тэгш бус.

- Тусламж, үйлчилгээний зохицуулалт (Хуулийн төслийн 59-65 дугаар зүйл). Хуулийн төслийн 59.6-д эмчилгээний зардлыг даатгалын сангаас санхүүжүүлэхээр




заасан нь зөв боловч даатгалд хамрагдаагүй эмзэг бүлгийн иргэдэд хүрэх механизм тодорхойгүй. Хуулийн төслийн 62 дугаар зүйлд Донтох эмгэгийг нөхөн сэргээх үндэсний төвд 14 чиг үүрэг хариуцуулсан нь институцийн чадавхыг хэтрүүлэх эрсдэлтэй; Хуулийн төслийн 62.2-т орон нутгийн төвийг "байгуулж болно" гэсэн сонголттой зохицуулалт нь хүртээмжийн тэгш бус байдлыг хэвээр хадгалах боломжийг бүрдүүлэхээр байна. Хуулийн төслийн 63.3-т албадан эмчилгээний явцад мэдээллийг цагдаагийн байгууллагад мэдэгдэхээр тусгасан шаардлага нь Эрүүл мэндийн тухай хуулийн 43.1.7-д заасан эмнэлзүйн нууцлалын зарчим, пропорциональ байдлын шалгууртай зөрчилдөж болзошгүй байна. Хуулийн төслийн 64.4-т "төлбөртэй" тусламжийн хувилбар нь нийгмийн эмзэг бүлгийн хүртээмжийг сулруулна нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

- Мэдээллийн сангийн зохицуулалт (Хуулийн төслийн 66-70 дугаар зүйл). Мэдээллийн нэгдсэн сан бий болгох нь Үндэсний хөтөлбөрийн зорилтод нийцсэн боловч хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас үзэхэд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр нэгдсэн сан өнөөдрийг хүртэл үүсгэгдээгүй, зөвхөн бэлтгэл ажил хийгдсэн. Хуулийн төслийн 68.1.8-д өвчтний нэр, хаяг, нас, хүйс, оношийг цагдаагийн удирдлагын мэдээллийн санд хадгалахаар заасан нь ХХМХТХ-ийн 5.1 дэх зарчимтай зөрчилдөх эрсдэлтэй болно. Хуулийн төслийн 70.1.1-д мансууруулах бодис хэрэглэгчдийн бүртгэл цуглуулахаар заасан нь хэрэглэгчдийн "нэрсийн жагсаалт" бий болгох утгатай бөгөөд 58 дугаар зүйлийн "эрх зүйн байдлыг дордуулахгүй" зарчимтай шууд зөрчилдөнө. Мөн EMCDDA-ын порталд заасан хувийн мэдээллийн хамгаалалтын стандарт (мэдээллийн хамгийн бага байдлын зарчим, нэвтрэх эрхийг чиг үүргээр ялгах зарчим)-ыг хангах шаардлагатай.

- Урьдчилан сэргийлэх зохицуулалт (Хуулийн төслийн 71 дүгээр зүйл). Хуулийн төслийн 71.1-д хилийн боомтод 4 хэлээр сэрэмжлүүлэг тавихаар тусгасан шаардлага нь олон улсын практикт нийцсэн. Гэхдээ хуулийн төслийн 71.2-т тусгасан хориглолтод ноцтой асуудлууд тогтоогдов: нэгд, "мэдээлсэн" ба "сурталчилсан"-ын ялгааг тогтоогоогүй нь боловсролын агуулга, баримтат кино, "хор хөнөөлийг бууруулах" (harm reduction) сургалтыг "сурталчилгаа" гэж хамруулж болзошгүй; хоёрт, "далд сурталчилгаа" гэсэн нэр томъёог нарийн тодорхойлолтгүй; гуравт, Хуулийн төслийн 71.2.3-т "аливаа сурталчилгаа" гэсэн нэр томъёо нь эмийн компани, боловсролын байгууллага, кино урлагийн салбарт хуулийн тодорхойгүй байдлын ачаалал хүлээлгэж байна; дөрөвт, Хуулийн төслийн 71.3-т гурван ялгаатай байгууллагад нэгэн зэрэг хариуцлага хүлээлгэсэн нь уялдааны тогтолцоогүй бол давхардал бий болгоно.

Зөвлөмж

1. Ангиллын жагсаалтыг батлах үйл явцад мэргэжлийн бие даасан зөвлөх хорооны (фармакологи, токсикологи, эпидемиологийн мэргэжилтнүүд) зөвлөмжийг заавал авах журмыг хуульчлах;
2. Хуулийн төслийн 58 дугаар зүйлд 16-17 насны өсвөр үеийнхний зөвшөөрлийг авах нөхцөлийг нэмэх; Хуулийн төслийн 58.4, 58.5-ын хамрах хүрээг гуравдагч этгээдийг хориглох байдлаар өргөтгөх;
3. Даатгалд хамрагдаагүй, эмзэг бүлгийн иргэдэд тусламж хүргэх механизмыг нэмэх;
4. Хуулийн төслийн 62 дугаар зүйлийн чиг үүргийг цөөлж, зарим чиг үүргийг бусад байгууллагуудад хуваарилах; орон нутгийн төвийг "байгуулж болно" гэснийг тодорхой нөхцөлтэй "байгуулна" гэсэн агуулгаар өөрчлөх;

- 
5. Хуулийн төслийн 63.3 дахь хэсэгт тусгасан мэдэгдлийн заалтыг пропорциональ байдлын зарчимд нийцүүлэн хязгаарлах;
 6. Хуулийн төслийн 68.1.8, 70.1.1-д тусгасанхүний хувийн мэдээлэлтэй холбоотой зохицуулалтыг ХХМХтХ-ийн шаардлагатай нарийвчлан нийцүүлж, мэдээлэл хадгалах хугацаа, хандах эрхийн түвшин, устгах журмыг тусгах;
 7. Хуулийн төслийн 71.2-д "мэдээлсэн" ба "сурталчилсан" гэж тусгасан нэр томьёоны ялгааг тодорхойлж, боловсролын, эрүүл мэндийн, баримтат гэсэн зорилго бүхий агуулгыг хориглолтоос хасах (контекст-хамаарсан хандлага);
 8. Хуулийн төслийн 71.3-т заасан гурван байгууллагын чиг үүргийн зааг, уялдааны тогтолцоог тодорхой болгох.

Ойлгомжтой байдал, Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Судалгааны тус 2 шалгуур үзүүлэлтийг хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлсэн бөгөөд холбогдох дүгнэлт, саналыг тухай бүр нь гаргасан учир судалгааны холбогдох хэсгийн дүгнэлт, саналтай танилцана уу.


Ерөнхий дүгнэлт

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийн үр нөлөөг 5 шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн судалгааны нэгдсэн дүгнэлтийг дараах байдлаар томьёолов.

Хуулийн төсөл нь Монгол Улсын мансууруулах бодисын хяналтын эрх зүйн орчныг мэдэгдэхүйц сайжруулах, одоогийн 2002 оны хуулийн хийдэл, дутагдлыг арилгахад чухал алхам болохоор байна. Хуулийн төсөл зорилгодоо ерөнхийдөөхүрсэн, НҮБ-ын гурван конвенцийн шаардлагыг хангахад чиглэсэн, одоогийн хэрэгжилтийн практикад суурилсан зохицуулалтуудыг хуулийн түвшинд хүлээн авсан бөгөөд олон улсын хандлагатай нийцсэн шинэлэг зохицуулалтуудыг (нийтийн эрүүл мэндийн хандлага, эрт илрүүлэх, нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ, мэдээллийн нэгдсэн сан) тусгасан нь сайн талтай бөгөөд эерэг үр дүнд хүрэхээр байна.

Гэвч хуулийн төслийг батлахын өмнө дараах нийтлэг чиглэлээр зарим засвар, нэмэлт оруулах шаардлагатай:

1. Дугаарлалтын болон эшлэлийн алдааг засварлах.
2. Нэр томьёоны тодорхойлолтыг (4 дүгээр зүйл) боловсронгуй болгож, тодорхойлоогүй 7 нэр томьёог нэмж, нуршуу тодорхойлолтыг бүтэцлэж, дарааллыг зөв тодорхойлох.
3. Цахим мэдээллийн нэгдсэн системийг бий болгох хуваарь, шилжилтийн хугацааг хуулийн төслийн шилжилтийн үеийн зохицуулалтад нэмж тусгах.
4. Мэргэжлийн бие даасан зөвлөх хорооны оролцоог бодисын ангилал, бодлогын шийдвэр гаргалтад хуулийн түвшинд тогтоох.
5. Хүний эрхийн олон улсын стандарт (НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, ICCPR, ДЭМБ-ын стандарт)-тай нийцүүлэх, ялангуяа эмнэлзүйн нууцлал, пропорциональ байдлын зарчмыг хангах, мэдээллийн нэгдсэн сангийн хувийн мэдээллийн хамгаалалтыг ХХМХтХ-ийн шаардлагад нийцүүлэх.

- 
6. Санхүүжилтийн эх үүсвэр, хуваарилалтын журмыг тодорхой болгож, орон нутгийн төсвийн ачааллыг бодитой тооцох.
 7. Цахим худалдаа, darknet, мессенжер зэрэг дижитал орчинд бодис түгээхтэй тэмцэх тусгай зохицуулалтыг нэмэх.
 8. Зарим техникийн шаардлага өндөртэй зохицуулалтыг (хилийн лаборатори, тээврийн тоног төхөөрөмж, хадгалалтын систем) шатлан хэрэгжүүлэх хугацаатай болгох.
 9. Хуулийн төслийн 71 дүгээр зүйлийн хориглолтод "мэдээлсэн" ба "сурталчилсан" гэж тусгасан нэр томъёог тодорхой зааглаж, боловсролын, баримтат зорилго бүхий агуулгыг хориглолтоос хасах.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж

А. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он;
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, 1966 он;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц, 1988 он;
- Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, 1961 он;
- НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948 он;
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 он;
- Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенц, 1971 он.
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001 он;
- Байгалийн ургамлын тухай хууль, 1995 он;
- Гаалийн тухай хууль, 2021 он;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2016 он;
- Зөрчлийн тухай хууль, 2017 он;
- Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль, 2012 он;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, 2002 он;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993 он;
- Нийтийн мэдэгдэлийн ил тод байдлын тухай хууль, 2021 он;
- Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, 2018 он;
- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2006 он;
- Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он;
- Хүний хувийн мэдэгдэл хамгаалах тухай хууль, 2021 он;
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, 2010 он;
- Эрүүгийн хууль, 2015 он;
- Эрүүл мэндийн тухай хууль, 2011 он;
- Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар";
- Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам";
- Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт;
- Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт;
- Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал";
- Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр";
- Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 247 дугаар тогтоол "Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай";
- Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт;
- Засгийн газрын 2025 оны 29 дүгээр тогтоол;

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/227 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Химийн шинжилгээ хийх журам";
- Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам";
- Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/408 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, экспортлох, хадгалах, устгах, түгээх, худалдах үйл ажиллагааг зохицуулах журам";
- Төрийн мэдэгдэл, тусгай дугаар IV боть, Монгол Улсын олон улсын гэрээ, 2006 он;
- Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал";

Б. Ном, сурах бичиг


- Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх (Харьцуулсан эрх зүй), 1999 он;
- Г.Эрдэнэбат, Хүний халдашгүй эрх, 2002 он;
- Монгол Улсын дээд шүүх, Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2013 он;

В. Эрдэм шинжилгээний бүтээл

- Б.Болдбаатар, "Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал", "Хар тамхины гэмт явдал: шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам" сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2018 он;
- О.Мөнхсайхан, "Монгол Улсын үндсэн хууль: туйлын эрхээс бусад үндсэн эрхийн хязгаарлалтад тавих гол нөхцөл", Хууль зүйн судалгаа, анализ, бичлэг хичээлийн материал, 2021 он;
- С.Жанцан, "Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудал", илтгэл, 2012 он.

Г. Бусад

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ", 2023 он;
- ИРИМ Нийгэм, бодлогын тусгаар судалгааны хүрээлэн, "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих Үндэсний хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ", 2019 он;
- Монгол Улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал, судалгааны тайлан, 2013 он;
- ХЗҮХ, "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ", 2024 он;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн товч танилцуулга, 2024 он;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2024 он;



2. Гадаад хэл дээрх эх сурвалж

- Directive 2001/83/EC of the European Parliament and of the Council on the Community Code Relating to Medicinal Products for Human Use, 2001.
- Lin M., Amon J.J., "No Exit: China's State Surveillance over People Who Use Drugs", Health and Human Rights Journal 24, no. 1, 2022.
- Open Government Partnership, "Mongolia National Action Plan 2024-2028", 2024.
- Organisation for Economic Co-operation and Development (OECD), Guiding Principles for Regulatory Quality and Performance, Paris: OECD, 2005.
- Steinebach Y., Knill C., "How policy growth affects policy implementation: bureaucratic overload and policy triage", Journal of European Public Policy 30, no. 1, 2023. doi: 10.1080/13501763.2022.2158208.
- United Nations Office on Drugs and Crime (UNODC), International Standards on Drug Use Prevention, 2nd updated ed., Vienna: UNODC, 2018.
- United Nations Office on Drugs and Crime (UNODC), Transnational Organized Crime in East Asia and the Pacific: A Threat Assessment, Vienna: UNODC, 2024.
- United Nations Office on Drugs and Crime (UNODC), World Drug Report 2024, Vienna: UNODC, 2024.
- World Health Organization (WHO), International Standards for the Treatment of Drug Use Disorders, Geneva: WHO, 2020.
- Betäubungsmittelgesetz (BtMG): Gesetz über den Verkehr mit Betäubungsmitteln, 1971.

3. Цахим эх сурвалж

- Европын мансууруулах бодис, донтолтын хяналтын төвийн цахим хуудас: <https://www.emcdda.europa.eu>
- Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудас: <https://www.police.gov.mn>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn>
- НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын цахим хуудас: <https://www.unodc.org>
- Нээлттэй Засгийн газрын түншлэлийн цахим хуудас: <https://www.opengovpartnership.org>